

ОЛОН СОЁЛТ ГЭР БҮЛИЙН ЭЦЭГ
ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ЭЛСЭЛТИЙН
ГАРЫН АВЛАГА
ХҮҮХДЭЭ СҮРГҮҮЛЬД
ОРҮҮЛАХ нь



I. СУРГУУЛЬД ЭЛСЭН ОРОХ ТУХАЙ

- | | |
|-------------------------------------|----|
| 1. Цэцэрлэгт орох тухай | 07 |
| 2. Бага сургуульд элсэн орох тухай | 10 |
| 3. Дунд сургуульд элсэн орох тухай | 11 |
| 4. Ахлах сургуульд элсэн орох тухай | 12 |



II. СУРГУУЛЬД ОРОХ · ШИЛЖИН СУРАЛЦАХ ТУХАЙ

Гадаадад амьдарч байгаад ирсэн болон гадаад иргэншилтэй сурагч

- | | |
|--|----|
| 1. Сургуульд орох · шилжин суралцах тухай | 15 |
| 2. Олон соёлт гэр бүлийн хүүхдийн боловсролын түвшинг тогтоох нь | 17 |



III. БОЛОВСРОЛД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТОГТОЛЦОО

- | | |
|--|----|
| 1. Олон соёлт гэр бүлийн хүүхдэд боловсрол олгох байгууллага | 18 |
| 2. Олон соёлт гэр бүлийн хүүхдийн боловсролд үзүүлэх дэмжлэг | 20 |
| 3. Сургалтын төлбөрт үзүүлэх дэмжлэг | 20 |
| 4. Сургуульд сурахад үзүүлэх дэмжлэг | 21 |



Хавсралт

- | | |
|--|----|
| 1. 'Солонгос улсын боловсролын тогтолцоо, анги дэвшин суралцах тухай мэдээлэл' эцэг эхчүүдэд зориулсан видео танилцуулга | 22 |
| 2. Сургуулийн орчинд хэрэглэгддэг үг хэллэг | 23 |
| 3. Апостилийн гэрээнд нэгдсэн орнууд | 29 |

ОЛОН СОЁЛТ ГЭР БҮЛИЙН ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН
ЭЛСЭЛТИЙН ГАРЫН АВЛАГА

ХҮҮХДЭЭ СҮРГҮҮЛЬД ОРУУЛАХ НЬ

ЭНЭХҮҮ ТОВХИМЛЫГ 12 ХЭЛЭЭР ОРЧҮҮЛАН ХҮРГЭЖ БАЙНА

한국어 (한국어)		English (영어)	
Tiếng Việt (베트남어)		中文 (중국어)	
Tagalog (타갈로그어)		日本語 (일본어)	
ภาษาไทย (태국어)		Монгол (몽골어)	
русский (러시아어)		한국어 (크메르어)	
မြန်မာ (미얀마어)		Français (프랑스어)	
عربي (아랍어)		Олон соёлт гэр бүлийн боловсрол ын портал (edu4mc.or.kr)	

※ Олон соёлт гэр бүлийн эцэг эхчүүдэд зориулсан элсэлтийн гарын авлага 「Хүүхдээ сургуульд оруулах нь」-н PDF файлыг олон соёлын боловсролын портал (www.edu4mc.or.kr)-с татан авч болно.

Солонгос улсын боловсролын тогтолцоо

•• Солонгос улсын боловсролын тогтолцоог Цэцэрлэг-бага-дунд-ахлах-дээд сургуулийн боловсрол гэж ангилдаг.

- Цэцэрлэг 3 жил, бага сургууль 6 жил, дунд сургууль 3 жил, ахлах сургуульд 3 жил сурдаг бөгөөд жилд хоёр улирлаар хичээллэнэ. Ихэнхдээ 1-р улирлын хичээл 3 сарын эхээр, 2-р улирлын хичээл 8 сарын сүүлээс 9 сарын эхний хооронд эхэлдэг.
- Цэцэрлэгийн сургалт хүмүүжлийн ажил тоглоомон дээр суурилсан нэгдсэн сургалтын хэлбэрээр явагддаг бол бага · дунд · ахлах сургуулийн сургалт ерөнхий боловсрол эзэмшүүлэх сургалт болон бүтээлч ажил, дадлага сургалтын хэлбэрээр явагддаг.
- Заавал эзэмших боловсролыг бага сургуульд 6 жил, дунд сургуульд 3 жилийн сургалтаар үнэ төлбөргүй олгоно.

※ Жич, хувийн хэвшлийн бага сургууль, тусгай мэргэжлийн сургалттай дунд сургууль(Үрлаг · спорт · олон улсын дунд сургууль зэрэг) төлбөртэй байдаг.

•• Оршин суух зөвшөөрөлтэй эсэхээс үл хамааран бага, дунд, ахлах сургуульд элсэн суралцах боломжтой.

- Солонгос улсын "Бага · дунд боловсролын тухай хууль" болон НҮБ-ын "Хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын гэрээ(United Nations Convention on the Rights of the Child, UNCRC)" –ний заалтын дагуу бага · өсвөр насны хүүхдийн боловсрол эзэмших эрхийг хамгаалах үүднээс хүүхэд бүр оршин суух статусаас үл хамааран бага, дунд сургуульд элсэн суралцах эрх нь хамгаалагдсан байдаг.
- Эцэг эхчүүд бичиг баримтын зөрчил нь илрэхээс болгоомжлон хүүхдээ сургуульд оруулаагүй тохиолдол байдаг. Хүүхдийн боловсрол эзэмших эрхийг хамгаалах үүднээс хүүхдээр нь дамжуулан хууль бусаар оршин суугаа иргэдийг шалгаж саатуулдаггүй.

•• Олон соёлт гэр бүлийн эв найртай амьдралын орчинг бүрдүүлэхийн тулд бүх сурагчид хамтдаа суралцаж, өсөн хөгжихөд нь дэмжин тусалж байна.

- Нийт сурагчдад олон соёлын боловсрол олгох, олон соёлт гэр бүлийн хүүхдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор цэцэрлэг, бага · дунд · ахлах сургуулиуд дундаас олон соёлын боловсролын бодлого хэрэгжүүлэх сургуулийг сонгон итгэмжилж · үйл ажиллагааг удирдан явуулж байна
- Олон соёлын боловсролын бодлогыг хэрэгжүүлж буй сургуулиудаас "Солонгос хэлний анги" нээн · ажиллуулж буй сургуульд солонгос хэл · соёлын эрчимжүүлсэн сургалт явуулж, солонгос сургуульд дасан зохицоход нь тусалж, шаардлагатай суурь боловсрол олгож байна

[СОЛОНГОС УЛСЫН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦОО]

Боловсролын тогтолцоо		Суралцах хугацаа	Нас	Сургалтын төлбөр	Тайлбар
Сургуулийн өмнөх боловсрол	Цэцэрлэг	3 жил	3~5 нас	Төлбөртэй/төлбөргүй	-
Бага боловсрол	Бага сургууль	6 жил	6~11 нас	Төлбөртэй/төлбөргүй	Заавал эзэмших боловсрол
Дунд боловсрол	Дунд сургууль	3 жил	12~14 нас	Төлбөртэй/төлбөргүй	Заавал эзэмших боловсрол
	Ахлах сургууль	3 жил	15~17 нас	Төлбөртэй/төлбөргүй	-
Дээд боловсрол	Их дээд сургууль	4 жил	18 наснаас дээш	Төлбөртэй	-
	Коллеж	2~3 жил			
	Магистрант, докторантын сургалт	2~5 жил			

I

СУРГУУЛЬД ЭЛСЭН ОРОХ ТУХАЙ



Нас	Сургуулийн ангилал										
3~5 нас	<p style="text-align: center;">Цэцэрлэгт орох</p> <p>[Эцэг эхийн бүрдүүлэх материал] "Чоём хакгюру(www.go-firstschool.go.kr)" вэб хуудас" –нд нэвтрэн анкет бөглөж бүртгүүлнэ</p> <table border="1"> <tr> <td data-bbox="372 425 565 620"> 10~12 сарын үед (Тухайн цэцэрлэгээс хамаараад өөр байна) </td> <td data-bbox="569 425 1335 620"> <ul style="list-style-type: none"> • "Чоём хакгюру(www.go-firstschool.go.kr)" – д нэвтэрч гишүүнээр элсэнэ • Цэцэрлэгүүдийн бүртгэлийн зартай танилцана. <ul style="list-style-type: none"> ※ Цэцэрлэгийн хүүхэд элсүүлэх журамд олон соёлт гэр бүлийн хүүхэд элсүүлэх тухай заалт байгаа эсэхийг шалгана • Цэцэрлэгт орох өргөдлийн анкет бүртгүүлэх, бүртгэлийн мэдээллийн хуудсыг шалгана (Хэвлэж авах боломжтой) • Сугалааны шалгаруулалтын хариуг шалгаж, цэцэрлэгт элсэгчээр бүртгүүлэх • Чиглүүлэх сургалт өдөрлөгт оролцоно </td> </tr> <tr> <td data-bbox="372 626 565 698"> Дараа жилийн 1~2 сарын үед </td> <td data-bbox="569 626 1335 698"> <ul style="list-style-type: none"> • Хүүхэд нэмж авах зарын дагуу бүртгүүлж, хариуг шалгана • Цэцэрлэгт бүртгүүлнэ • Чиглүүлэх сургалт өдөрлөгт оролцоно </td> </tr> <tr> <td data-bbox="372 704 565 735"> 3 сарын эхээр </td> <td data-bbox="569 704 1335 735"> <ul style="list-style-type: none"> • Хичээлийн шинэ жилийн нээлт </td> </tr> </table>	10~12 сарын үед (Тухайн цэцэрлэгээс хамаараад өөр байна)	<ul style="list-style-type: none"> • "Чоём хакгюру(www.go-firstschool.go.kr)" – д нэвтэрч гишүүнээр элсэнэ • Цэцэрлэгүүдийн бүртгэлийн зартай танилцана. <ul style="list-style-type: none"> ※ Цэцэрлэгийн хүүхэд элсүүлэх журамд олон соёлт гэр бүлийн хүүхэд элсүүлэх тухай заалт байгаа эсэхийг шалгана • Цэцэрлэгт орох өргөдлийн анкет бүртгүүлэх, бүртгэлийн мэдээллийн хуудсыг шалгана (Хэвлэж авах боломжтой) • Сугалааны шалгаруулалтын хариуг шалгаж, цэцэрлэгт элсэгчээр бүртгүүлэх • Чиглүүлэх сургалт өдөрлөгт оролцоно 	Дараа жилийн 1~2 сарын үед	<ul style="list-style-type: none"> • Хүүхэд нэмж авах зарын дагуу бүртгүүлж, хариуг шалгана • Цэцэрлэгт бүртгүүлнэ • Чиглүүлэх сургалт өдөрлөгт оролцоно 	3 сарын эхээр	<ul style="list-style-type: none"> • Хичээлийн шинэ жилийн нээлт 				
	10~12 сарын үед (Тухайн цэцэрлэгээс хамаараад өөр байна)	<ul style="list-style-type: none"> • "Чоём хакгюру(www.go-firstschool.go.kr)" – д нэвтэрч гишүүнээр элсэнэ • Цэцэрлэгүүдийн бүртгэлийн зартай танилцана. <ul style="list-style-type: none"> ※ Цэцэрлэгийн хүүхэд элсүүлэх журамд олон соёлт гэр бүлийн хүүхэд элсүүлэх тухай заалт байгаа эсэхийг шалгана • Цэцэрлэгт орох өргөдлийн анкет бүртгүүлэх, бүртгэлийн мэдээллийн хуудсыг шалгана (Хэвлэж авах боломжтой) • Сугалааны шалгаруулалтын хариуг шалгаж, цэцэрлэгт элсэгчээр бүртгүүлэх • Чиглүүлэх сургалт өдөрлөгт оролцоно 									
	Дараа жилийн 1~2 сарын үед	<ul style="list-style-type: none"> • Хүүхэд нэмж авах зарын дагуу бүртгүүлж, хариуг шалгана • Цэцэрлэгт бүртгүүлнэ • Чиглүүлэх сургалт өдөрлөгт оролцоно 									
3 сарын эхээр	<ul style="list-style-type: none"> • Хичээлийн шинэ жилийн нээлт 										
6~11 нас	<p style="text-align: center;">Бага сургуульд элсэн орох</p> <p>[Эцэг эхийн бүрдүүлэх материал] Сургуульд элсэн орох тухай мэдэгдлийн хуудсыг хүлээн авч, сургуульд орох хувийн бэлтгэл хийнэ</p> <table border="1"> <tr> <td data-bbox="372 844 565 984"> Сургуульд орохын өмнөх жилийн 12 сарын 20-ныг хүртэл </td> <td data-bbox="569 844 1335 984"> <ul style="list-style-type: none"> • Сургуульд элсэн орох тухай мэдэгдлийн хуудас: Харьяа баг, хорооны захиргаанаас мэдэгдэнэ (Орох сургуулийн нэр, он сар өдрийг тэмдэглэсэн байна) <ul style="list-style-type: none"> ※ Харьяа баг-сум-хорооны захиргаанаас элсэн орох сургуулийн захирлын нэр дээр хүүхдийн овог нэр-иргэний бүртгэлийн дугаар-оршин суугаа хаяг, асран хамгаалагчийн овог нэр-төрсөн он сар өдөр, холбоо барих утасны дугаар бүхий мэдэгдлийн хуудас хүргүүлнэ. ※ Гадаадын иргэншилтэй хүүхдийн нэр дээр сургуульд орох мэдэгдлийн хуудас очихгүй. </td> </tr> <tr> <td data-bbox="372 990 565 1021"> 1 ~ 2 сар </td> <td data-bbox="569 990 1335 1021"> <ul style="list-style-type: none"> • Сургууль бүрийн чиглүүлэх сургалт : Сургуульд элсэн орох тухай танилцуулга </td> </tr> <tr> <td data-bbox="372 1026 565 1057"> 3 сарын эхээр </td> <td data-bbox="569 1026 1335 1057"> <ul style="list-style-type: none"> • Хичээлийн шинэ жилийн нээлт </td> </tr> </table>	Сургуульд орохын өмнөх жилийн 12 сарын 20-ныг хүртэл	<ul style="list-style-type: none"> • Сургуульд элсэн орох тухай мэдэгдлийн хуудас: Харьяа баг, хорооны захиргаанаас мэдэгдэнэ (Орох сургуулийн нэр, он сар өдрийг тэмдэглэсэн байна) <ul style="list-style-type: none"> ※ Харьяа баг-сум-хорооны захиргаанаас элсэн орох сургуулийн захирлын нэр дээр хүүхдийн овог нэр-иргэний бүртгэлийн дугаар-оршин суугаа хаяг, асран хамгаалагчийн овог нэр-төрсөн он сар өдөр, холбоо барих утасны дугаар бүхий мэдэгдлийн хуудас хүргүүлнэ. ※ Гадаадын иргэншилтэй хүүхдийн нэр дээр сургуульд орох мэдэгдлийн хуудас очихгүй. 	1 ~ 2 сар	<ul style="list-style-type: none"> • Сургууль бүрийн чиглүүлэх сургалт : Сургуульд элсэн орох тухай танилцуулга 	3 сарын эхээр	<ul style="list-style-type: none"> • Хичээлийн шинэ жилийн нээлт 				
	Сургуульд орохын өмнөх жилийн 12 сарын 20-ныг хүртэл	<ul style="list-style-type: none"> • Сургуульд элсэн орох тухай мэдэгдлийн хуудас: Харьяа баг, хорооны захиргаанаас мэдэгдэнэ (Орох сургуулийн нэр, он сар өдрийг тэмдэглэсэн байна) <ul style="list-style-type: none"> ※ Харьяа баг-сум-хорооны захиргаанаас элсэн орох сургуулийн захирлын нэр дээр хүүхдийн овог нэр-иргэний бүртгэлийн дугаар-оршин суугаа хаяг, асран хамгаалагчийн овог нэр-төрсөн он сар өдөр, холбоо барих утасны дугаар бүхий мэдэгдлийн хуудас хүргүүлнэ. ※ Гадаадын иргэншилтэй хүүхдийн нэр дээр сургуульд орох мэдэгдлийн хуудас очихгүй. 									
	1 ~ 2 сар	<ul style="list-style-type: none"> • Сургууль бүрийн чиглүүлэх сургалт : Сургуульд элсэн орох тухай танилцуулга 									
3 сарын эхээр	<ul style="list-style-type: none"> • Хичээлийн шинэ жилийн нээлт 										
12~14 нас	<p style="text-align: center;">Дунд сургуульд элсэн орох</p> <p>[Эцэг эхийн бүрдүүлэх материал] Байхгүй(Холбогдох материалыг бага сургуулиас нэгдсэн журмаар бэлдэнэ)</p> <table border="1"> <tr> <td data-bbox="372 1135 565 1166"> 1 сарын дундуур </td> <td data-bbox="569 1135 1335 1166"> <ul style="list-style-type: none"> • Дунд сургуулийн хуваарь гаргана(Түүвэр сугалааны аргаар гаргадаг) </td> </tr> <tr> <td data-bbox="372 1172 565 1203"> 1 сарын эцсээр </td> <td data-bbox="569 1172 1335 1203"> <ul style="list-style-type: none"> • Дунд сургуульд хуваарилагдсан сурагчдын нэрсийн жагсаалтыг зарлаж, чиглүүлэх сургалт өдөрлөг зохион байгуулна </td> </tr> <tr> <td data-bbox="372 1208 565 1239"> 2 сарын дундуур </td> <td data-bbox="569 1208 1335 1239"> <ul style="list-style-type: none"> • Дахин, нэмэлт хуваарилалт явуулах хүсэлт, анги хуваарилалт явагдана </td> </tr> <tr> <td data-bbox="372 1244 565 1275"> 2 сарын дунд~эцэс </td> <td data-bbox="569 1244 1335 1275"> <ul style="list-style-type: none"> • Нэмэлт хуваарилалтын хариуг мэдэгдэнэ </td> </tr> <tr> <td data-bbox="372 1281 565 1312"> 3 сарын эхээр </td> <td data-bbox="569 1281 1335 1312"> <ul style="list-style-type: none"> • Хичээлийн шинэ жилийн нээлт </td> </tr> </table>	1 сарын дундуур	<ul style="list-style-type: none"> • Дунд сургуулийн хуваарь гаргана(Түүвэр сугалааны аргаар гаргадаг) 	1 сарын эцсээр	<ul style="list-style-type: none"> • Дунд сургуульд хуваарилагдсан сурагчдын нэрсийн жагсаалтыг зарлаж, чиглүүлэх сургалт өдөрлөг зохион байгуулна 	2 сарын дундуур	<ul style="list-style-type: none"> • Дахин, нэмэлт хуваарилалт явуулах хүсэлт, анги хуваарилалт явагдана 	2 сарын дунд~эцэс	<ul style="list-style-type: none"> • Нэмэлт хуваарилалтын хариуг мэдэгдэнэ 	3 сарын эхээр	<ul style="list-style-type: none"> • Хичээлийн шинэ жилийн нээлт
	1 сарын дундуур	<ul style="list-style-type: none"> • Дунд сургуулийн хуваарь гаргана(Түүвэр сугалааны аргаар гаргадаг) 									
	1 сарын эцсээр	<ul style="list-style-type: none"> • Дунд сургуульд хуваарилагдсан сурагчдын нэрсийн жагсаалтыг зарлаж, чиглүүлэх сургалт өдөрлөг зохион байгуулна 									
	2 сарын дундуур	<ul style="list-style-type: none"> • Дахин, нэмэлт хуваарилалт явуулах хүсэлт, анги хуваарилалт явагдана 									
	2 сарын дунд~эцэс	<ul style="list-style-type: none"> • Нэмэлт хуваарилалтын хариуг мэдэгдэнэ 									
3 сарын эхээр	<ul style="list-style-type: none"> • Хичээлийн шинэ жилийн нээлт 										
15~17 нас	<p style="text-align: center;">Ахлах сургуульд элсэн орох</p> <ul style="list-style-type: none"> • Энгийн сургалттай ахлах сургууль(Үүнд Чөлөөт тогтолцоот ахлах сургууль багтана) • Гүнзгийрүүлсэн сургалттай ахлах сургууль: Гадаад хэл, олон улс, байгалийн шинжлэх ухаан, урлаг, биеийн тамирын сургалттай ахлах сургууль • Тусгай мэргэжлийн сургалттай ахлах сургууль: Тусгай(мэргэжил), Тусгай(дүйцэх боловсрол олгох сургууль), Мастер ахлах сургууль • Бусад: Онцгой авъяастай хүүхдийн сургууль <ul style="list-style-type: none"> ※ Ахлах сургууль, хот•мужийн Боловсролын Газарын онцлогоос шалтгаалан элсэлтийн журам, бүртгэлийн хугацаа харилцан өөр өөр байна. ※ Дэлгэрэнгүй мэдээллийг "Ахлах сургуулиудын элсэлтийн журмын тухай мэдээллийн хуудас(www.hischool.go.kr)" –наас үзнэ үү 										
18 наснаас дээш	<p style="text-align: center;">Их, дээд сургууль</p>										

1) Цэцэрлэгийн бүртгэлийн систем болох "Чоём хакгюру(www.go-firstschool.go.kr)"-г ашиглах боломжгүй бол цэцэрлэг дээр очиж бүртгүүлэх боломжтой.

01 Цэцэрлэгт орох тухай



Цэцэрлэгийн өмчийн хэлбэр

- **Төрийн өмчит цэцэрлэг:** Төрөөс байгуулан үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэг
- **Орон нутгийн өмчит цэцэрлэг:** Орон нутгийн өөрөө удирдах байгууллагаас байгуулан үйл ажиллагаа явуулж буй хот-мужийн өмчийн цэцэрлэг
- **Хувийн хэвшлийн цэцэрлэг:** Хувь хүн, хуулийн этгээдийн байгуулан үйл ажиллагаа явуулж буй цэцэрлэг

Хамрагдах хүүхэд


- Цэцэрлэгт **3 нас ~ бага сургуульд элсэх хүртэлх насны хүүхэд** орох боломжтой.

Элсэлтийн хугацаа

- **Хичээлийн шинэ жилийн элсэлт:** Цэцэрлэгийн хичээлийн жил 3 сарын 1-нээс дараа жилийн 2 сар хүртэл үргэлжлэх бөгөөд **хичээлийн шинэ жил нь ихэвчлэн 3 сард** эхэлдэг.
- **Албан бус элсэлт:** Тухайн цэцэрлэгийн нөхцөл байдлаас хамаараад **албан бус элсэлт авах** тохиолдол ч байдаг тул тухайн цэцэрлэгээс хүүхэд оруулах боломжтой эсэхийг лавлана.

Элсэлтийн журам

- Цэцэрлэгийн бүртгэл, элсэн орох бүхий л ажиллагаа Цэцэрлэгийн бүртгэлийн систем буюу **“Чоём хакпору”** веб хуудас(www.go-firstschool.go.kr)-р явагдана.



Q TIP Амьдарч байгаа дүүрэгт харъяалагдах цэцэрлэгийг хайх

▶ Амьдарч байгаа дүүрэгтээ харъяалагдаж байгаа цэцэрлэгийн мэдээллийг **‘Цэцэрлэгийн бүртгэлийн систем(Чоём хакпору)’, ‘Ючивон аллими’** вэб хуудаснаас авах боломжтой. Мөн цэцэрлэгт хүүхэд элсүүлэх журам, хугацаа, сургалтын үйл ажиллагааны тухай мэдээлэл ч авах боломжтой.

- **Чоём хакпору(www.go-firstschool.go.kr):** Цэцэрлэгийн насны хүүхдийн эцэг эхчүүд(асран хамгаалагч) хүссэн үедээ, хүссэн газраасаа цэцэрлэгийн тухай мэдээлэл авч, бүртгүүлэх, шалгаруулалтын хариу харах боломж бүхий цэцэрлэгийн бүртгэлийн цахим систем юм.
- **Цэцэрлэгийн мэдээлэл(e-childschoolinfo.moe.go.kr):** Дүүрэгтээ харъяалагдаж байгаа цэцэрлэг, түүний үйл ажиллагааны тухай мэдээллийг авах боломжтой.

▶ Бага насны хүүхдэд боловсрол олгох байгууллагыг сонгохдоо дараах 4 нөхцлийг баримтлах нь зүйтэй.

- **[Байрлал]** Гэр болон эцэг эхийнх нь ажлын газартай ойрхон газар
 - Цэцэрлэг гэрээс нь хол байдаг хүүхэд ядарч стрессэнд ордог.
- **[Боловсролын тухай үзэл бодол]** Эцэг эхийн боловсролын тухай үзэл бодолд тохирсон газар
 - Цэцэрлэг тус бүр боловсрол олгох тухай өөрийн гэсэн онцлог, арга барилтай байдаг тул ямар сургалтын хөтөлбөр дээр голлон ажиллаж байгааг нь сайн ажиглаж судална.
- **[Цэцэрлэгийн байр]** Аюулгүй байдал, эрүүл ахуйн орчин сайн хангагдсан газар
 - Хүүхэд цэцэрлэг дээр бүтэн өдөр өнждөг тул хүүхдийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангасан, төрөл бүрийн үйл ажиллагаа явуулах боломжтой орчин хангалттай бүрдсэн эсэхийг сайн ажиглаж судална.
- **[Багш]** Харилцааны өндөр чадвартай багш
 - Бага насны хүүхдийн өсөж хөгжих, хүмүүжлийн энэ насанд эерэг хандлагатай багшийн харилцаа чухал байдаг.

Цэцэрлэгт орох хүсэлт гаргах

- Бүртгүүлэх хугацаа
 - Тухайн орон нутаг, цэцэрлэгийн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалаад өргөдөл хүлээн авах хугацаа нь хоорондоо ялгаатай байдаг боловч **ихэвчлэн 10~11 сарын хооронд дараа жилийн хичээлийн шинэ жилийн элсэлтийн бүртгэл явагддаг.**
- Бүртгүүлэх арга
 - Цэцэрлэгт орох өргөдлийг **онлайнаар** болон **цэцэрлэг дээр очиж бүртгүүлэх** бөгөөд нэг хүүхэд дээд тал нь 3 цэцэрлэгт өргөдөл гаргах боломжтой.
 - **Онлайн бүртгэл:** Эцэг эх(асран хамгаалагч) ‘Чоём хакгюру’ вэб хуудсаар дамжуулан цэцэрлэгт орох өргөдлийг бүртгүүлнэ.
 - **Цэцэрлэг дээр очиж бүртгүүлэх:** Тухайн цэцэрлэг дээр очвол таны өмнөөс цэцэрлэгт орох өргөдлийг бүртгүүлж өгч болно.
 - Цэцэрлэгт орох өргөдлийн бүртгэлийг **эн түрүүнд элсүүлэх хүүхэд, ердийн элсэлт гэж** ангилдаг. **Эн түрүүнд элсүүлэх хүүхдийн тоонд олон соёлт гэр бүлийн хүүхдийг оруулсан тохиолдол байдаг тул энэ тухай цэцэрлэгээс лавлана уу.**
 - Олон соёлт гэр бүлийн хүүхэд мөн гэдгийг нотлох материалыг цэцэрлэгийн зүгээс нэмж шаардах тохиолдол байдаг тул энэ тухай бүртгэлийн зар болон тухайн цэцэрлэгээс лавлана уу.

Цэцэрлэгийн хүүхэд сонгон шалгаруулж, элсүүлэх тухай

- Цэцэрлэгийн хүүхдийг бүртгүүлсэн дарааллаар нь сонгон шалгаруулж элсүүлдэггүй. Бүртгүүлсэн хүүхдийн тоо элсүүлэх хүүхдийн тооноос хамааран сугалаагаар шалгаруулан элсүүлдэг. Шалгаруулалтын хариуг ‘Чоём хакгюру’ вэб хуудас болон бүртгүүлсэн утасны дугаарт явуулсан мессежнээс шалгана.
- Бүртгүүлсэн бүх цэцэрлэгийн сугалаанд таараагүй болон сугалаа таарсан цэцэрлэгт оруулахаас татгалзсан тохиолдолд элсэлтийн тоо нь гүйцээгүй цэцэрлэгт хүүхдээ оруулж болно. Нэмэлт элсэлтийн мэдээллийг ‘Чоём хакгюру’ вэб хуудаснаас мэдэх боломжтой.
- Цэцэрлэгт орох эцсийн шийдвэр гарвал эцэг эх(асран хамгаалагч)–үүд цэцэрлэгийн чиглүүлэх сургалт өдөрлөгт оролцож, цэцэрлэгт орохоос өмнө заавал мэдвэл зохих мэдээлэлтэй танилцана.

Цэцэрлэгт орох бэлтгэл ажил

- Цэцэрлэгт орох бэлтгэл ажлыг эцэг эхийн бэлтгэх зүйлс, хүүхдийг цэцэрлэгт ороход бэлтгэх гэж ангилна.
 - **Эцэг эхийн бэлтгэх зүйлс:** Сургалтын төлбөрийн тэтгэлэг авах боломжтой эсэх, цэцэрлэгт ороход шаардлагатай нэмэлт материал(эцэг эх нь хоёлаа ажил хийдэг бол хүүхдээ албан сургалтын дараах хөтөлбөрт хамруулах өргөдөл зэрэг), зураг, цэцэрлэгийн зүгээс шаардаж буй бусад эд зүйлсийг бэлдэнэ.
 - ※ Эцэг эхчүүд хичээлийн шинэ жилийн нээлт хийхээс өмнө цэцэрлэгийн чиглүүлэх сургалт өдөрлөгт оролцож хангалттай мэдээлэл авах шаардлагатай. Мөн хүүхдээ цэцэрлэгт оруулахаас өмнө тухайн цэцэрлэг дээр дагуулан очих нь цэцэрлэгтээ хурдан дасгахад дөхөмтэй байдаг.
 - **Хүүхдээ цэцэрлэгт ороход бэлтгэх:** Ахуйн аюулгүй байдлын тухай зааж сургах, эцэг эх(асран хамгаалагч)–с нь хол, тусад нь байлгаж дасгах, үеийнх нь хүүхдүүдтэй тоглуулах, ахуйн ерөнхий зуршил(бие засах, хооллох зуршил)–г хэвшүүлэх, цэцэрлэгийн автобусанд суухад анхаарах зүйлсийг зааж сургана.





Хичээлийн жил, анги хуваарилалт

- Сургуулийн өмнөх боловсрол олгох сургалт нь жилд хоёр улирлаар явагдана.
 - **дүгээр улирал** : 3 сарын 1 (3 сарын 1-нд улсын хэмжээний тэмдэглэлт өдөр таардаг тул 3 сарын 2-нд хичээл эхэлдэг)–нээс цэцэрлэгийн хичээл-амралтын хоног, хичээлийн явцыг тооцоолон цэцэрлэгийн эрхлэгчийн гаргасан сар өдөр хүртэл (ихэвчлэн 8 сарын дунд эцсээр таардаг)
 - **дугаар улирал** : 1 дүгээр улирлын хичээл дууссаны маргаашнаас дараа жилийн 2 сарын эцэс хүртэл
- Сургуулийн өмнөх боловсролын сургалт нь өдөрт 4~5 цаг үргэлжлэх бөгөөд хичээлийн дараа хүүхэд саатуулах болон бусад сургалтын хөтөлбөр явагддаг.
- Тухайн цэцэрлэгийн нөхцөл боломж, сургалтын арга барилаас хамаараад 3 нас, 4 нас, 5 нас, хол имог насны анги гэж хуваагдана.

Хичээлийн хоног, хичээлд орох

- Сургуулийн өмнөх боловсролын хичээлийн жилийн хоногийг жилд **180-с дээш хоног** байхаар тухайн цэцэрлэгийн эрхлэгч тогтоон хэрэгжүүлдэг.

Сургалт (Тоглоомд суурилсан сургалт)

- Сургуулийн өмнөх сургалтыг “**Нури буюу тоглоомд суурилсан сургалт**” гэх бөгөөд энэ сургалтын зорилго нь бага насны хүүхдийг тоглож байгаа тоглоомоороо дамжуулан сэтгэл зүй, эрүүл мэндийн хувьд өв тэгш өсөж торниход нь тусалж, ардчилсан нийгмийн иргэн болох суурийг тавьж өгөхөд оршино.
- Нури сургалт нь 5 хэсэг(биеийн идэвхтэй хөдөлгөөн•эрүүл мэнд, хэл яриа, нийгмийн харилцаа, урлаг, байгалийн ажиглалт) –с бүрдэх бөгөөд тухайн тоглоом бүртэй сургалт хүмүүжлийн ажлыг нэгтгэн зангидаж өгдөг.
- Нури сургалтанд тулгуурлан тухайн байдалд тохирсон төлөвлөгөө гарган хэрэгжүүлдэг бөгөөд тухайн цэцэрлэгийн хичээлийн хуваарьт гадаа тоглуулах цагийг оруулах зэргээр бага насны хүүхдүүдийг хангалттай тоглох нөхцөлийг бүрдүүлэн ажилладаг.

Өдрийн хуваарь

- Бага-дунд-ахлах сургуулиас ондоо зүйл нь цэцэрлэгт сурах бичиг байдаггүй. Цэцэрлэгт бага насны хүүхдийг сонирхол, шохооролдоо тохирсон тоглоомдоо чөлөөтэй оролцож, хөгжилтэй байлгахыг зорин ажилладаг.
- Цэцэрлэгийн нэг өдрийн хуваарийг бүрдүүлдэг тоглоом, өдөр тутамд хийдэг зүйлс, үйлдэл бүрээсээ хүүхдүүд янз бүрийн зүйл сурч байдаг. Гадаа тоглох цагийг оролцуулан тооцвол өдрийн хуваарийн хамгийн олон цагийг тоглох цаг эзэлдэг.
 - Өдөр тутмын хийдэг зүйлст цэцэрлэгт ирэх, гараа угаах, 00 орох, хөнгөн зуушны цаг, өдрийн хоолны цаг, өдрийн унтлага, амралтын цаг зэрэг багтдаг. Үүний үр дүнд хүүхэд бие махбодийн хувьд эрүүл, чийрэг байж, цэцэрлэгийн орчинд өдрийг хөгжилтэй өнгөрөөдөг юм.
 - Хүүхдийг тоглож байгаа тоглоомдоо тулгуурлан орчин, нийгмээ танин, мэдэж суралцахад нь багшийн тус дэмжлэг зайшгүй шаардлагатай юм. Тиймээс багш нар хүүхдүүдийн тоглоомыг илүү үр дүнтэй болгож, дэмжих үүднээс үйл хөдлөл, үйлдэлд нь төлөвлөгөө гарган ажилладаг. Жишээлбэл) аюулгүй байдлын сургалт, шинэ дуу сурах, ярилцах, үлгэр сонсох зэрэг

02 БАГА СҮРГҮҮЛЬД ЭЛСЭН ОРОХ ТУХАЙ



Бага сургуулийн өмчийн хэлбэр

- **Төрийн өмчит бага сургууль:** Төрөөс байгуулан үйл ажиллагааг нь удирдан зохион байгуулж байгаа бага сургуулиуд болон Боловсролын Их Сургууль, Үлсын Их Сургуулийн боловсролын дээд сургуулийн харъяа бага сургуулиуд
- **Орон нутгийн өмчит бага сургууль:** Орон нутгийн өөрөө удирдах байгууллагаас байгуулан үйл ажиллагааг нь удирдан зохион байгуулж байгаа бага сургуулиуд
- **Хувийн хэвшлийн бага сургууль:** Хувь хүн, хуулийн этгээдийн байгуулан үйл ажиллагааг нь удирдан зохион байгуулж байгаа бага сургуулиуд


Сургуульд элсэх(орох) хүүхэд

- 1 сарын 1–нээс 12 сарын 31–ны хооронд **6 нас хүрсэн хүүхэд бага сургуульд элсэн орох үүрэгтэй.**
- **2021 онд сургуульд орох хүүхэд: 2014 оны 1 сарын 1–нээс~12 сарын 31–ний хооронд төрсөн хүүхэд**
- **2022 онд сургуульд орох хүүхэд: 2015 оны 1 сарын 1–нээс~12 сарын 31–ний хооронд төрсөн хүүхэд**

Элсэлтийн хугацаа

- Бага сургуулийн хичээлийн нэг жил 3 сарын 1–нээс дараа жилийн 2 сарын эцэс хүртэл үргэлжлэх бөгөөд **бага сургуулийн хичээлийн шинэ жилийн нээлт ихэвчлэн 3 сард** болдог. Сургуулийн сургалтын хөтөлбөрийг гүйцэн **суралцах чадвартай гэж үзвэл сургуульд явцын дундаас нь элсэн суралцах** боломжтой.

Элсэлтийн журам



- Та хүүхдээ сургуульд элсэн орох хүүхдийн нэрсийн жагсаалтад орсон эсэхийг харьяа хороо, баг сумын захираганаас лавлаж болно. 12 сарын 20–ноос өмнө хүүхэд сургуульд орох тухай мэдэгдлийн хуудсыг гэрийн хаягаар хүргүүлдэг.
- Ихэвчлэн хот, мужийн Боловсролын Газараас харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд **эцэг эхийнх нь оршин суугаа хаягийн дагуу элсэн орох сургуульд нь хуваарилах бөгөөд Олон соёлт гэр бүлийн хүүхдийн хувьд олон соёлт хүүхдэд зориулсан тусгай ангитай бага сургуульд элсэн орж болно.**
- Төрийн өмчит болон хувийн хэвшлийн өмчийн бага сургуулиуд дотоод журмынхаа дагуу сурагчдаа сонгон шалгаруулан элсүүлдэг тул орохыг хүсч **байгаа сургуулиасаа бүртгэлийн хугацааг нь лавлан асуух** хэрэгтэй.

Q TIP Гадаад иргэдийн хүүхэд сургуульд элсэн орох тухай

- ▶ Солонгос улсад төрсөн гадаад иргэдийн хүүхдийн нэр дээр сургуульд орох мэдэгдлийн хуудас очдоггүй тул солонгост амьдарч байгааг нотлох баримтыг бүрдүүлэн гэртээ ойрхон бага сургууль дээр очиж зөвлөгөө авна уу.
- ▶ Оршин суух статусгүй гадаад иргэний хүүхэд ч гэсэн сургуульд орох боломжтой тул түрээсийн байрны гэрээ, хаягийн тодорхойлолтын баталгаа(айл хөршийн хүний хийж өгсөн оршин суудаг нь үнэн болохыг нотлох бичиг) зэрэг оршин сууж байгааг нотлох баримт, хүүхдийн төрсөн он сар өдрийг нотлох бичиг баримтыг бүрдүүлнэ.

03 ДУНД СҮРГҮҮЛЬД ЭЛСЭН ОРОХ ТҮХАЙ




Хамрагдах хүүхэд

- Бага сургууль төгссөн юмуу түүнтэй дүйцэх боловсрол эзэмшсэн нь нотлогдсон хүүхэд дунд сургуульд элсэн суралцах үүрэгтэй.

Элсэлтийн хугацаа

- Дунд сургуулийн хичээлийн жил 3 сарын 1-нээс дараа жилийн 2 сарын эцэс хүртэл хичээллэх бөгөөд **дунд сургуулийн хичээлийн шинэ жилийн нээлт нь ихэвчлэн 3 сард** болдог. Сургуулийн сургалтын хөтөлбөрийг гүйцэн суралцах чадвартай гэж үзвэл **сургуульд явцын дундаас нь элсэн суралцах** боломжтой

Дунд сургуульд элсэх журам



- Ихэвчлэн сургуулиудын нягтшил, тойргийг харгалзан хот, мужийн Боловсролын Газараас харьяа нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд **элсэн орох сургуульд нь хуваарилах бөгөөд Олон соёлт гэр бүлийн хүүхдийн хувьд олон соёлт сурагчдад зориулсан тусгай ангитай дунд сургуульд элсэн** орж болно.
- Хэрвээ таны хүүхэд бага сургуульд сурч байгаа бол тухайн **сургуулиас дунд сургуульд элсэн ороход шаардлагатай бүхий л бичиг баримтыг бүрдүүлдэг тул эцэг эх(асран хамгаалагч)-н зүгээс тусгайлан бэлдэх зүйл байхгүй.**
- Жич, Спорт-урлаг-олон улсын дунд сургууль зэрэг **төрөлжсөн тусгай сургалттай сургуулиудын** хувьд сургууль бүр өөрийн онцлогоос хамаараад тусгай нөхцөл хангасан сурагчдыг сонгон шалгаруулан элсүүлдэг. Сургуулиудын шинээр элсэгчдийг сонгон шалгаруулах нөхцөл, журам, арга харилцан адилгүй байдаг тул **тухайн сургуулийн элсэлтийн журамтай танилцах хэрэгтэй.**

[Дунд сургуулиудын элсэлтийн журам]

Ангилал	Энгийн сургалттай дунд сургууль	Төрөлжсөн, тусгай сургалттай дунд сургууль
Онцлог	<ul style="list-style-type: none"> Сурагчдыг хүйсээр нь ангилсан эмэгтэйчүүдийн дунд сургууль, эрэгтэйчүүдийн дунд сургууль 	<ul style="list-style-type: none"> Аль нэг онцгой салбарт авъяас, чадвартай сурагчдыг сонгон шалгаруулж-сургана Биеийн тамирын дунд сургууль, Урлагийн дунд сургууль, Олон улсын сургууль зэрэг
Сургалтын төлбөр (Элсэлтийн хураамж, хичээлийн төлбөр)	<ul style="list-style-type: none"> Төлбөргүй 	<ul style="list-style-type: none"> Төлбөртэй(Сургууль тус бүр өөр өөр байна)
Элсэлтийн журам	<ul style="list-style-type: none"> Боловсролын Газараас сургуулиудын нягтшил-дунд сургуулийн харъяалагдах тойргийг харгалзан хуваарилдаг 	<ul style="list-style-type: none"> Сонгон шалгаруулах тусдаа журмын дагуу элсүүлдэг

TIP Бага, дунд, ахлах сургуулийн хичээлийн дараах хөтөлбөр

- Бага орлоготой өрх, эцэг эх нь хоёулаа ажил хийдэг гэр бүлийн бага сургуульд явдаг хүүхдүүдийг хичээлийн дараа саатуулан харах хөтөлбөрт хамруулах үйлчилгээ үзүүлнэ.
- Бага сургуулийн сурагчид хичээл, сургалтын болон өөрийн авъяас, онцлогт тохирсон авъяас хөгжүүлэх төрөл бүрийн хичээлийн дараах хөтөлбөрт хамрагдаж болно.
- Хамрагдан суралцаж болох эсэх, хамрах хүрээ зэргийг хот, мужийн Боловсролын Газараас лавлан асууна уу.



Ахлах сургуулийн өмчийн хэлбэр

- **Энгийн сургалттай ахлах сургууль:** Орон нутаг · хувийн өмчийн хэлбэртэй ерөнхий боловсрол олгох ахлах сургуулиудыг хэлэх бөгөөд ахлах сургуулиудын дунд хамгийн их хувийг эзэлдэг.
- **Төрөлжсөн, тусгай сургалттай ахлах сургууль:** Гадаад хэл, олон улс, байгалийн шинжлэх ухаан зэрэг тусгай салбарын мэргэжлийн төрөлжсөн сургалт бүхий ахлах сургууль
- **Тусгай мэргэжлийн сургалттай ахлах сургууль:** Гарын дүй, үр чадвартай хүүхдүүдийг тусгай мэргэжлийн салбарын боловсон хүчнээр бэлтгэх зорилго бүхий сургалт, ажлын байран дээрх ижил орчинд дадлага туршлага эзэмшүүлэн, мэргэжлийн түвшинд сургалт явуулдаг ахлах сургууль
- **Чөлөөт тогтолцоот сургалттай ахлах сургууль:** Бусад ахлах сургуультай харьцангуйгаар сургалт, хүмүүжлийн ажлын хөтөлбөрийг чөлөөтэй сонгож явуулахаар журамлагдсан төрийн өмчит · хувийн хэвшлийн ахлах сургууль

Хамрагдах хүүхэд

- Дунд сургууль төгссөн болон түүнтэй дүйцэхүйц боловсрол эзэмшсэнийг нотлох бичиг баримттай хүүхэд ахлах сургуульд элсэн суралцах боломжтой.

Элсэлтийн хугацаа

- Ахлах сургуулийн хичээлийн жил 3 сарын 1–нээс дараа жилийн 2 сарын эцэс хүртэл хичээллэх бөгөөд **ахлах сургуулийн хичээлийн шинэ жилийн нээлт нь ихэвчлэн 3 сард** болдог.

Элсэлт авах хугацаа

- Ахлах сургуульд шинээр элсэгчдийг нэг, хоёрдугаар ээлжийн элсэлтээр сонгон шалгаруулан элсүүлдэг.
 - Нэгдүгээр ээлжийн элсэлт: Энгийн сургалттай ахлах сургууль(урлаг-биеийн тамир), төрөлжсөн сургалттай ахлах сургууль(байгалийн шинжлэх ухаан/урлаг/биеийн тамир болон үйлдвэрлэлийн салбарт шаардлагатай боловсон хүчин бэлтгэх сургалттай ахлах сургууль)
 - Хоёрдугаар ээлжийн элсэлт: Энгийн сургалттай ахлах сургууль(урлаг-биеийн тамирын сургалттай сургуулиас бусад) болон нэгдүгээр ээлжийн элсэлтэд хамрагдаагүй бүх ахлах сургууль
- Тухайн хот-мужийн Боловсролын Газарын үйл ажиллагааны онцлогоос хамаараад бүртгэлийн хугацаа, элсэлтийн журам нь харилцан өөр өөр байдаг тул сайн танилцан судалж бүртгүүлнэ үү.

[Ахлах сургуулийн элсэлтийн журам]

Ангилал	Дэлгэрэнгүй	Зорилго	Элсэлтийн журам
Энгийн сургалттай ахлах сургууль	Энгийн сургалттай ахлах сургууль	• Дунд сургуульд эзэмшсэн боловсрол дээр суурилан дараах шатны боловсрол эзэмшүүлэх сургалт явуулна	• Харьяа тойрог: Сугалаа • Бусад тойрог: Голч дүн зэрэг
	Гадаад хэлний сургалттай ахлах сургууль	• Гадаад хэлний өндөр мэдлэгтэй боловсон хүчин бэлтгэн гаргах	• Сургууль тус бүрийн элсэлтийн шалгалтын комиссоос тогтоосон суралцагчыг элсүүлэх тухай журам
Төрөлжсөн тусгай сургалттай ахлах сургууль	Олон улсын ахлах сургууль	• Олон улсын улс төр, болон гадаад харилцааны салбарын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэн гаргах	
	Байгалийн шинжлэх ухааны сургалттай ахлах сургууль	• Байгалийн шинжлэх ухааны салбарын боловсон хүчин бэлтгэн гаргах	
	Үрлагийн, Биеийн тамирын ахлах сургууль	• Үтгэ зохиол, хөгжим, урлаг, бужиг, жүжиг, кино зэрэг урлагийн салбарын боловсон хүчин бэлтгэн гаргах	
Тусгай мэргэжлийн сургалттай ахлах сургууль	Мастер ахлах сургууль	• Ирээдүйтэй онцгой үйлдвэрлэлийн хэрэгцээ шаардлагатай үйлдүүлэн залуу мастер (Young Meister) боловсон хүчин бэлтгэх сургалт	• Голч дүн, ярилцлага, үр чадварын шалгалт зэрэг
	Тусгай (мэргэжил олгох)	• Төгсөөд ажилд гарахыг хүссэн сурагчдад мэргэжлийн боловсрол олгох сургууль	• Голч дүн, ярилцлага, үр чадварын шалгалт зэрэг
Чөлөөт тогтолцоот сургалттай ахлах сургууль	Тусгай(дүйцэх боловсрол олгох сургууль)	• Сурагч төвтэй чөлөөт хөтөлбөрийн сонголтот сургалт бүхий сургууль	
	Чөлөөт тогтолцоот сургалттай ахлах сургууль	Чөлөөт тогтолцоот сургалттай хувийн ахлах сургууль	• Тухайн сургуулийн үйл ажиллагааны онцлогийг тусгасан сургалт, хөтөлбөр бүхий сургууль
Бусад	Орон нутгийн өмчит чөлөөт тогтолцоот сургалттай ахлах сургууль	• Харьяалах орон нутгийн Боловсролын Газарын даргын зөвшөөрлийн дагуу боловсролын тогтолцооны шинэчлэл, хөгжлийн төлөө сургалтын хөтөлбөр нь хараат бус, чөлөөт тогтолцоотой байна.	• Харьяа тойрог: Сугалаа • Бусад тойрог: Голч дүн зэрэг
	Гоц авьяаснуудын сургууль	• Нүүгдмал авьяасыг илрүүлэхийн тулд тусгай сургалт шаардлагатай гоц авьяастай хүүхдүүдийн үр чадварт нь тохирсон сургалт явуулна.	• Сугалаа болон шалгалтын комиссоор хэлэлцэх

※ Дэлгэрэнгүй мэдээллийг "Ахлах сургуулийн элсэлтийн портал сайт(www.hischool.go.kr)"-аас авна үү.

Хичээлийн жил, анги хуваарилалт

- Бага · дунд · ахлах сургууль жилд хоёр улирлаар хичээллэдэг.
 - дүгээр улирал : 3 сарын 1 (3 сарын 1-нд улсын тэмдэглэлт өдөр таардаг тул 3 сарын 2-нд хичээл эхэлдэг)-с сургуулийн захирлын хичээл-амралтын хоногийг тооцоолон тогтоосон өдөр(ихэвчлэн зуны амралтын сүүлийн өдөр) хүртэл
 - 2 дугаар улирал : 1 дүгээр улирлын сүүлийн өдрийн маргаашнаас дараа жилийн 2 дугаар сарын сүүлийн өдөр
- Анги хуваарилахдаа ихэвчлэн насаар нь ангилан хуваарилдаг боловч шаардлагатай тохиолдолд насны зөрүүтэй хүүхдүүдээр анги бүрдүүлэх тохиолдол байдаг.

Хичээлийн хоног, хичээлд суух

- Ихэнх сургууль **долоо хоногт 5 өдөр(Даваа-Баасан)** буюу хичээлийн нэг жилд **190-с дээш хоног хичээллэдэг** боловч тухайн сургуулийн онцлогоос шалтгаалаад харилцан адилгүй байж болно.
- Тухайн хичээлийн жилийн хичээлийн нийт хоногийн 2/3-т нь сууж байж дараагийн ангид дэвши н суралцах боломжтой болно. Жич, **хичээлийн жилийн дундуур шилжиж ирсэн олон соёлт гэр бүлийн хүүхдийн хувьд шилжиж ирснээс хойш, үлдсэн хичээлийн жилийн 2/3-т хамаарах хугацаанд сууж байж дараагийн ангид элсэн суралцах боломжтой болно.**
- Байгалийн гамшигт үзэгдэл(газар хөдлөлт, үер, зуд, далайн шуурга зэрэг), хуулинд заасан халдварт өвчин, сургуулийн захирлын зөвшөөрөлтэйгээр албан ёсны уралдаан тэмцээнд оролцох, та нилцах сургалт дадлага, харилцаа-солилцооны сургалт хөтөлбөр, сургуулийн ажлаас гадуурх сургалт, аялал (хамаатныдаа зочлох, гэр бүлийн аялал зэрэг), баяр, эмгэнэлт үйл ажиллагаанд оролцсон тохиолдолд чөлөөний хуудас бөглөж өгвөл хичээл тасалсанд тооцохгүй. Мөн сургуулийн захирлын зөвшөөрөлтэйгээр хичээлд суугаагүй тохиолдолд сууснаар тооцно.
- Сургуулийн ажлаас гадуурх аялал, сургалтанд явахын өмнө чөлөөний хуудас бөглөж анги даасан багшдаа өгнө. Аялалаас буцаж ирээд товч тайлан бичиж өгөх шаардлагатай. Сургуулийн ажлаас гадуурх аялал сургалт нь сургуулиас өгч буй боловсролд сөрөг нөлөө үзүүлэхээргүй бол сургуулийн дотоод журмын дагуу оролцох боломжтой. Тухайн сургуулийн үйл ажиллагааны онцлогоос хамаараад чөлөөний хугацаа өөр өөр байна.

Сургуулийн амралт

- Сурагчдын зуны амралт ихэвчлэн 7 сарын сүүлээр эхэлж 1 сар орчим үргэлжилдэг. Өвлийн амралт 1 сарын эхнээс 2 сарын сүүл хүртэл үргэлжлэх бөгөөд тухайн сургуулийн үйл ажиллагааны онцлогоос хамаараад өвлийн амралтын хугацааг богиносгон хавар амруулах(төгсөлтийн өмнөх амралт, дараа жилийн 2 сарын дундаас сүүл хүртэл 2 долоо хоног) тохиолдол ч байдаг.

Сургуулийн хөтөлбөрт хамрах хичээл

- Сургуулийн сургалтын үйл ажиллагааг **хичээл, бүтээлч үйл ажил** гэж ангилна. **Бүтээлч үйл ажил нь** сургалтын хүрээнээс гадуурх бие даасан чөлөөт үйл ажиллагаа, дугуйланд хамрагдах, сайн санааны үйлс, ирээдүйн ажил мэргэжил сонгох зэрэг 4 хэсгээс бүрдэнэ.

[Бүтээлч үйл ажлын хамрах хүрээ, үйл ажиллагаа]

Сургалтын хүрээ	Зохион байгуулах ажил	Сургалтын хүрээ	Зохион байгуулах ажил
Бие даасан чөлөөт үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Дасан зохицох • Чаддаг, мэддэг зүйлээ зааж сургах • Идэвхтэй үйл ажиллагаа • Бүтээлч үйл ажилл 	Дугуйлан	<ul style="list-style-type: none"> • Судалгаа, шинжилгээний ажил • Соёлын үйл ажиллагаа • Спортын үйл ажиллагаа, • Дадлага сургалтын үйл ажиллагаа • Өсвөр насныхны бүлгийн ажил
Сайн санааны үйлс	<ul style="list-style-type: none"> • Сургууль доторх сайн санааны үйлс • Нийгмийн сайн санааны үйлс • Байгаль, хүрээлэн буй орчныг хамгаалах үйлс • Компанит ажилд оролцох 	Ирээдүйгээ төлөвлөх	<ul style="list-style-type: none"> • Өөрийгөө ойлгох • Мэргэжил тандах судалгаа • Ирээдүйн төлөвлөгөө гаргах • Ирээдүйн дадал бий болгох

II

СҮРГҮҮЛЬД ОРОХ · ШИЛЖИН СУРАЛЦАХ²⁾ ТҮХАЙ

: гадаадад амьдарч байгаад ирсэн болон гадаадын иргэншилтэй сурагч



Сургуульд орох · шилжин суралцах тухай

Оршин суугаа газрын харъяа сургууль болон хот, мужийн Боловсролын Газараас лавлах

[Сургуульд орох · шилжин суралцах тухай зөвлөгөө авах газар]

1. Бага сургууль – Оршин суугаа газрынхаа ойр орших сургууль
2. Дунд сургууль – Харьяалах тойргийн сургуулийн бүс: Оршин суугаа газрын харъяалах хот, мужийн Боловсролын Газар – Үл харъяалах тойргийн сургуулийн бүс: Оршин суугаа газрынхаа ойр орших дунд сургууль
3. Ахлах сургууль – Элсэн орохыг хүссэн ахлах сургууль

Сургуульд орох·шилжин суралцахад бүрдүүлэх материал³⁾

- Сургуульд орох, шилжин суралцах тухай өргөдөл – 1 хувь
- Хилээр нэвтэрсэн баримт эсвэл гадаад иргэний бүртгэлийн тодорхойлолт(Солонгос дахь оршин суугаа газрын бүртгэлийг нотлох баримт) –1 хувь
 - ※ Дээрхи материалыг бүрдүүлэх боломжгүй тохиолдолд "Байрны түрээсийн гэрээ, айл хөршийн хүний хийж өгсөн оршин суудаг нь үнэн болохыг нотлох бичиг" –г бүрдүүлэн өгч болно.
 - ※ Иргэний бүртгэлийн лавлагаа, гадаадын иргэний бүртгэлийн лавлагаа зэргийг өөр ямар нэг бичиг баримтын бүрдүүлэлт хийлгүй сургууль болон хот, мужийн Боловсролын Газараас захиргааны мэдээлэл олгох албаны портал(www.share.go.kr)–с шалгах боломжтой байдаг.
- Боловсролын түвшинг нотлох баримт⁴⁾ (Сургуулийн гэрчилгээ, сурч байгаа тодорхойлолт, дүнгийн хуудас зэрэг)

[Гадаад улсын боловсролын түвшин нь тогтоогдсон сургуулийн нэрсийн жагсаалтыг харах арга]

Ангилал	Агуулга
Боловсролын Яамны вэб хуудаснаас шалгах	<ul style="list-style-type: none"> • Апостиль эсвэл консулын газрын тодорхойлолт шаардахгүйгээр тухайн сургуулийн захирлын нэр дээр гаргасан баримтыг хүчинтэйд тооцно ※ Гадаад улсын боловсролын түвшин нь тогтоогдсон сургуулийн нэрсийн жагсаалтыг Боловсролын Яамны вэб хуудас(www.moe.go.kr)–ны Нүүр хуудас → [Бодлого, мэдээллийн булан] → [Бага · дунд · ахлах боловсрол] цэнээс харах боломжтой. ※ Баримтын нэр: Гадаад улсын боловсролын түвшинг нь тогтоогдсон бага, дунд, ахлах сургууль(Сургуулиас бүрдүүлэх бичиг баримтыг хялбаршуулсан сургууль)–ийн нэрсийн жагсаалт
Апостиль (APOSTILLE)–р баталгаажуулах	<ul style="list-style-type: none"> • Тухайн улсын эрх бүхий байгууллагаас гаргуулсан апостиль гэрчилгээтэй бичиг баримт ※ Апостилийн гэрчилгээтэй бичиг баримтыг БНСУ–ын гадаад улсад суугаа консулын албаны баталгаажуулалт шаардахгүйгээр албан бичиг баримтын нэгэн адил хүчинтэйд тооцно.
Консулын газрын баталгаа	БНСУ–ын гадаад улсад суугаа консулын газраас тухайн сургууль нь тус улсын ерөнхий боловсрол олгох албан ёс нь байгууллага мөн болохыг нотлох баримт гаргуулна
Үүнээс бусад тохиолдолд	Хүсэлт гаргагч тус улсын ерөнхий боловсрол олгох албан ёсны байгууллага(оршин суугаа улсын харъяа Боловсролын Газараас боловсролын түвшинг нь тогтоосон сургууль) мөн болохыг баталгаажуулна. (Оршин суугаа улсын харъяа Боловсролын Газарын вэб хуудаснаас боловсролын түвшинг нь тогтоосон сургуулийн нэрсийн жагсаалтыг хэвлэн авч хавсаргах зэрэг)

- Солонгос дотор сургууль шилжин суралцаж байгаа сурагчийн хувийн хэрэг(хамрагдах хүүхэд)
 - ※ Тухайн сургуулийн зүгээс тухайн сурагчийг дотоодын сургуулиас шилжин ирсэн эсэхийг шалгаж, шилжин ирсэн сургуулиас сурагчийн хувийн хэргийг хүсэлт гарган авна.
- Үрьдчилан сэргийлэх тарилга хийлгэсэн тухай тодорхойлолт⁵⁾
 - ※ Сурагч, оюутныг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнд хариу арга хэмжээ авах тухай журмын "гадаадаас суралцахаар шилжин ирсэн сурагчийн урьдчилан сэргийлэх тарилгын тухай"–тай танилцана уу.
- Хот · мужийн Боловсролын Газарын үйл ажиллагааны журмын дагуу бүрдүүлэх шаардлагатай бусад бичиг баримт (Харъяалах Боловсролын Газараас бүрдүүлэх бичиг баримтыг заавал лавлах шаардлагатай.)
- Сургуулийн зүгээс дээр дурьдсан баримтаас гадна шаардлагатай мэдээллийг шалгах зорилгоор гадаад паспортны хуулбар, ам бүлийн тодорхойлолт, иргэний бүртгэлийн тодорхойлолт(Солонгос улсын иргэншил авсан тохиолдолд) бүрдүүлж өгөхийг шаардах тохиолдол ч байдаг.

Сургуульд орох·шилжин суралцахдаа бүрдүүлэх материал

СҮРГҮҮЛЬД ОРОХ, ШИЛЖИН СУРАЛЦАХ ТҮХАЙ

2) Сургуульд орох: Заавал эзэмших боловсролын түвшинд харъяалах ангид орж суралцана. Шилжин суралцах: Заавал эзэмших боловсролын түвшинд үл хамаарах сурагч бол, өмнө нь сурч байгаад завсардсан сургуулийнхаа доод ангид дахин орж суралцах, эсвэл өөр сургуульд шилжин суралцах
 3) Тухайн хот·мужийн үйл ажиллагааны онцлогоос хамаараад сургуульд орох, шилжихэд бүрдүүлэх материал өөр өөр байж болно.
 4) Эзэмшсэн боловсролын түвшинг нотлох баримтад гадаад улсын ямар сургуульд, хэдий хугацаагаар суралцсаныг тодорхойлох бөгөөд сургууль төгссөн гэрчилгээ, сурсан сургуулийн тодорхойлолтод тухайн сургуульд орсон · сургуулиас гарсан он сар өдөр, дэвшин суралцсан ангийг бичиж, сургуулийн захирал гарын үсэг зурж, тамга дарсан байна.
 5) Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, түүнд арга хэмжээ авах тухай хууль,27 дугаар зүйл(Үрьдчилан сэргийлэх тарилга хийлгэсэн тухай тодорхойлолт)

01 Сургуульд орох · шилжин суралцах тухай



7 Боловсролын түвшин тогтооход тавигдах шаардлага

- Солонгос сургуульд орох, шилжин суралцахын тулд гадаад улсад эзэмшсэн ерөнхий боловсролын түвшинг дараах аргаар тогтооно.
 - Ерөнхий боловсролын сургуулийн **6-аас дээш ангид суралцаж төгссөн** : Бага сургууль төгссөнд тооцно
 - Ерөнхий боловсролын сургуулийн **9-с дээш ангид суралцаж төгссөн** : Дунд сургууль төгссөнд тооцно
 - Ерөнхий боловсролын сургуулийн **12 дугаар ангид суралцаж төгссөн** : Ахлах сургууль төгссөнд тооцно
- Гадаад улсад эзэмшсэн боловсролын түвшинг тогтоох боломжтой эсэхийг дараах аргаар шалгана.
 - Боловсролын Яамны **‘Гадаад улсын боловсролын түвшин нь тогтоогдсон сургууль’**-ийн нэрсийн жагсаалтад нэр нь орсон сургуулийн захирлын нэрээр гаргасан бичиг баримтыг а постиль болон консулын газрын тодорхойлтгүйг эр хүчинтэйд тооцно.
 - ※ Боловсролын түвшин нь тогтоогдсон гадаад улсын бага · дунд · ахлах сургуулийн нэрсийн жагсаалтыг [Боловсролын Яамны вэб хуудас(www.moe.go.kr) Нүүр хуудас·Бага·дунд·ахлах сургуулийн боловсрол]-с үзнэ үү.
 - Боловсролын Яамны **‘Гадаад улсын боловсролын түвшин нь тогтоогдсон сургууль’**-ийн нэрсийн жагсаалтад нэр ороогүй сургуулиас гаргасан бичиг баримтыг тухайн улсын ерөнхий боловсрол олгох албан ёсны байгууллага мөн эсэхийг а постиль, консулын албаар баталгаажуулсан байна.
 - **Апостилийн гэрээнд нэгдсэн орнууд**: Эзэмшсэн ерөнхий боловсролын түвшинг нотлох баримт бичигт а постиль гэрч илгээ гаргуулан солонгос хэл рүү орчуулж · нотротиар баталгаажуулсан байна. [Хавсралт 3] Апостилд элссэн орнуудын нэрсийн жагсаалтыг (р. 29)-с үзнэ үү. Апостилийн гэрээнд нэгдсэн орнуудын нэрсийн жагсаалтыг үзнэ үү.
 - **Апостилийн гэрээнд нэгдээгүй орноос гаргасан бичиг баримт**: Тодорхойлолт гаргасан сургууль тухайн улсын ерөнхий боловсрол олгох албан ёсны сургууль мөн эсэхийг баталсан тус улсад суугаа Солонгосын консулын газрын баталгаа бичгийг хавсаргана(БНСУ-ын ноториатын байгууллагаас гаргуулсан ноториат хүчингүй).

Q TIP Апостиль(Apostille) гэж юу вэ?

- ▶ Олон улсын гэрээний дагуу бичиг баримтыг гаргасан байгууллага, гарын үсэг, тамга дардас үнэн эсэхийг шалгаж гаргасан баталгаа бичгийг а постиль гэрчилгээ гэнэ. Өөрөөр хэлбэл гадаад улсаас гаргасан бичиг баримтыг хүлээн зөвшөөрөх, ашиглахын тулд баталгаажуулахыг а постиль гэх бөгөөд зөвхөн олон улсын апостилийн гэрээнд нэгдсэн орноос гаргасан апостилийн гэрчилгээ бүхий албан бичгийг хүчин төгөлдөрт тооцно.

※ Апостилийн гэрээнд нэгдсэн орнуудын нэрсийн жагсаалтыг [Хавсралт 3](р. 29)-с үзнэ үү.

▶ Апостилийн гэрчилгээ гаргуулах арга

- 1) Гадаад улсад сурч байсан сургуулиас гаргасан(сургуулийн захирлын овог нэр · тамга) боловсролын түвшинг нотлох бичиг баримтын эх хувь, ноториатаар баталгаажуулсан орчуулгын хувь
 - ※ Зөвхөн ноториатаар баталгаажуулсан орчуулгын материалд апостилийн гэрчилгээ гаргадаг.
- 2) Тухайн улсын гадаад харилцааны яам болон апостилийн гэрчилгээ гаргах байгууллагад хандаж а постиль хийлгэнэ(Apostille тэмдэг наана).
- 3) Сургуульд орох, шилжин суралцах тухай өргөдөл гаргахдаа апостилийн тэмдэг бүхий бичиг баримтыг албан бичигтэй дүйцүүлэн үзнэ.

б) Өмнөх боловсролын түвшинг нотлох баримт байхгүй байх юмуу дутуу тохиолдолд хот, мужийн Боловсролын Газарын боловсролын түвшинг тогтоох зөвлөл эсвэл тухайн сургуулийн боловсролын түвшин шалгах зөвлөлд боловсролын түвшин тогтоолгох хүсэлтээ гаргана

Шилжин суралцах сургуулиа сонгох

- Олон соёлт гэр бүлийн хүүхдэд зориулсан 'Олон соёлын боловсролын бодлого хэрэгжүүлэх сургууль' бол он солонгос хэл, соёлын боловсрол олгох эрчимт сургалт явуулах зорилго бүхий 'Солонгос хэлний анги' – т ай сургууль, олон соёлт гэр бүлийн хүүхдэд зориулсан боловсролын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн дүйц эх боловсрол олгох даалгавар гүйцэтгэн биелүүлэх сургууль зэрэг сургуулиуд үйл ажиллагаа явуулж байна.
- Хүүхдийнхээ орох · шилжин суралцах сургуулийг сонгохын өмнө харьяа тойргийнхоо сургууль, Боловсро л(дэмжих)–н Газар, Олон соёлын боловсролыг дэмжих төвд хандаж зөвлөгөө авна уу.

[Хот, мужийн Олон соёлын боловсролыг дэмжих төвтэй холбогдох утасны дугаар]

Төвийн нэр	Утасны дугаар	Төвийн нэр	Утасны дугаар
Сөүл хотын олон соёлын боловсролыг дэмжих төв	02-3999-058	Кангвон мужийн олон соёлын боловсролыг дэмжих төв	033-258-5524
Пусан хотын олон соёлын боловсролыг дэмжих төв	051-819-7062	Чүнбук мужийн олон соёлын боловсролыг дэмжих төв	043-210-2831~4
Дэгу хотын олон соёлын боловсролыг дэмжих төв	053-231-3930~6	Чүннам мужийн олон соёлын боловсролыг дэмжих төв	041-640-7542
Инчон хотын олон соёлын боловсролыг дэмжих төв	032-420-8265~9	Жонбук мужийн олон соёлын боловсролыг дэмжих төв	063-239-3474~5
Гуанжу хотын олон соёлын боловсролыг дэмжих төв	062-380-4361	Жоннам мужийн олон соёлын боловсролыг дэмжих төв	061-640-3330
Дэжон хотын олон соёлын боловсролыг дэмжих төв	042-616-8856	Кёнбук мужийн олон соёлын боловсролыг дэмжих төв	054-805-3264
Улсан хотын олон соёлын боловсролыг дэмжих төв	052-255-8180	Кённам мужийн олон соёлын боловсролыг дэмжих төв	055-210-5161~2
Сэжун хотын олон соёлын боловсролыг дэмжих төв	044-320-2414	Жэжүгийн олон соёлын боловсролыг дэмжи х төв	064-784-9040
Кёнги мужийн олон соёлын боловсролыг дэмжих төв	031-249-0452		

Сургуульд орох · шилжин суралцах өргөдөл гаргах

- Сургуульд орох · шилжин суралцахад шаардлагатай материалыг бүрдүүлэн сургууль болон Боловсролыг Дэмжих Газарт өөрийн биеэр хүсэлт гаргана.
- Сургуульд орох · шилжин суралцахад дараах үндсэн материалыг бүрдүүлэх бөгөөд тухайн хот · мужийн Б оловсролын Газарын үйл ажиллагаанаас хамаараад өөр өөр байж болно.

Баримтын нэр	Тайлбар
Сургуульд орох · шилжин суралцах өргөдөл	• Сургууль болон хот · мужийн Боловсролын Газарын албан ёсны маягт
Хүүхдийн хилээр зорчсон лавлагаа эсвэл гадаад иргэний бүртгэлийн лавлагаа ^{?)}	• Цагаачлал · гадаад иргэний хэрэг эрхлэх газарт очиж гаргуулж авна • 'Засгийн газар 24_вэб хуудас(www.gov.kr)–наас гарган авч болно(Ноториатаар баталгаажуулах шаардлагатай) ※ Тус баримтыг бүрдүүлэх боломжгүй тохиолдолд 'Түрээсийн байрны гэрээ', 'Айл хөршийн хүний хийж өгсөн оршин суудаг нь үнэн болохыг нотлох бичиг' зэрэг баримтаар орлуулж болно.
Гадаад улсад эзэмшсэн боловсролын түвшинг нотлох баримт	• Сургуулийн гэрчилгээ, сургуулийн тодорхойлолт ※ Апостилийн гэрчилгээ, консулын газрын баталгаа шаардлагатай ※ Гадаад улсын боловсролын түвшинг нь тогтоосон сургууль бол сургуулийн захирлын нэрээр гаргасан бичиг баримтыг хүчинтэйд тооцно. ※ Сургуульд элссэн, гарсан он сар өдөр, суралцаж байсан анги, сургуулийн захирлын тамга, тэмдэг
Үрждчилан сэргийлэх тарилга хийлгэсэн тодорхойлолт	• Оршин суугаа газрын ойролцоох эрүүл мэндийн төв дээр очих эсвэл 'Засгийн газар 24_ вэб хуудас (www.gov.kr)–наас авна(Ноториатар баталгаажуулах шаардлагатай)
Сургууль болон хот · мужийн Боловсролын Газарт бүрдүүлж өгөх бусад бичиг баримт	• Өмнө нь сурч байсан дотоодын сургуулийн сурагчийн хувийн хэрэг, хувийн мэдээлэл ашиглахыг зөвшөөрсөн бичиг, паспортны хуулбар, ам бүлийн тодорхойлолт, иргэний бүртгэлийн тодорхойлолт(С олонгос улсын иргэншил авсан тохиолдолд) зэрэг

Сургуульд орох · шилжин суралцах бүртгэл

- Сургуулиас материалын шалгалт хийж, боловсролын түвшин тогтоох зөвлөлийн хурлын тогтоолд үндэслэн д араах нөхцлийг харгалзан сургуульд оруулах · шилжүүлэн суулгах тухай шийдвэр гаргаж мэдэгдэнэ.
– Бага сургууль: Орох · шилжин суралцах гэж байгаа сургууль оршин суугаа газрын харьяа тойрогт хамаарч байгаа эсэх
– Дунд сургууль: Анги дүүргэлтийн хүрээн дотор зөвшөөрнө
– Ахлах сургууль: Сургалтын хөтөлбөрийг гүйцэж, суралцаж дүүргэх чадвартай гэж сургуулийн захирал зөвшөөрвөл
- Эцсийн шийдвэр гарвал эцэг эх(асран хамгаалагч) нь сургууль дээр очиж бүртгүүлнэ.



1 Олон соёлт гэр бүлийн хүүхдийн боловсролын түвшинг тогтоох зөвлөл

- Олон соёлт гэр бүлийн сургуулийн насны хүүхдийн хувьд Солонгосын бага · дунд · ахлах сургуульд ор ох(орох, элсэх, шилжин суралцах) хүсэлтээ гаргасан боловч өмнө эзэмшсэн боловсролыг түвшинг нотлох баримтгүй юмуу баримт нь дутуу бол **хот · мужийн Боловсролын Газарын Боловсролын түвшин тогтоох зөвлөл** болон тухайн сургуулийн боловсролын түвшин тогтоох зөвлөлд хандан боловсролын түвшингээ тогтоолгох тухай хүсэлт гаргаж болно.

Q TIP Боловсролын түвшин тогтоолгох шаардлагагүй тохиолдол

- ▶ Сургуульд орж суралцах шаардлагагүй, ахлах сургууль төгссөн боловсролын түвшинг зөвшөөрүүлэх тохиолдол
- ▶ Боловсролын түвшинг нотлох бичиг баримт байгаа бол
- ▶ Боловсролын түвшингээ баримтаар нотлож чадахгүй байх тохиолдол(бичиг баримт дутуу байх, бичиг баримт х оцорч ирэх, алдаа гарах зэрэг шалтгаан байж болно)

- **Боловсролын түвшин тогтоох зөвлөл нь** дүрвэгч, цагаач, хойд солонгосын дүрвэгч, бусад үүнтэй төстэй тохиолдолд боловсролын түвшинг тогтооход ээдрээтэй үлмаас сургуульд орох(элсэх, орох, шилжин суралцах) боломжгүй сурагч, мөн олон соёлт гэр бүлийн сургуулийн насны хүүхдүүд болон гадаад сурагчдын боловсролын түвшинг тогтоон, элсэн орж суралцах ангийг тодорхойлсон шийдвэр гаргадаг.

1 Боловсролын түвшин тогтоолгох тухай хүсэлт гаргах арга

① Бага сургууль, дунд сургууль(тойргийн бүс⁸⁾ бүсийн), ахлах сургууль: элсэн орохыг хүссэн сургуульдаа хүсэлт гаргана

② Дунд сургууль(тойргийн⁹⁾ бүсэд хамаарах)–д элсэх: Элсэхийг хүссэн сургуулийг харьяалах Боловсролын Газарт хүсэлт гаргана

- Олон соёлт гэр бүлийн хүүхдийн боловсролын түвшин тогтоох зарчим нь хот, мужийн Боловсролын Газар, сургууль бүрт өөр өөр байж болох боловч ерөнхийдөө дээрх зарчмын дагуу явагдах бөгөөд хүсэлт гаргахын тулд дараах материалыг бүрдүүлнэ.
 - Боловсролын түвшин тогтоолгох, анги хуваарилуулах тухай өргөдөл 1 хувь,
 - Паспортын хуулбар 1 хувь эсвэл төрсөн он сар өдрийг батлах албан бичиг 1 хувь
 - Хилээр орж ирсэн тухай нотолгоо эсвэл гадаад иргэний бүртгэлийн лавлагаа(оршин сууж байгаа тухай лавлагаа) 1 хувь
 - ※ Дээрх бичиг баримтыг бүрдүүлэх боломжгүй бол “түрээсийн гэрээ, оршин сууж байгааг нотлох айл, хөршийн хүний батлан даалт зэрэг оршин сууж байгааг тань нотлох баримт” –р орлуулж болно.
 - Боловсролын түвшинг батлах баримт 1 хувь(холбогдох баримт байгаа тохиолдолд)
 - ※ Боловсролын түвшинг батлах баримт англи болон бусад гадаад хэлээр байгаа бол орчуулсан хувийг нотариатаар баталгаажуулан эх хувийн хамт бүрдүүлж бэлдэнэ.
- Олон соёлт гэр бүлийн хүүхдийн боловсролын түвшинг тогтоохдоо боловсролын түвшин тогтоолгох тухай өргөдөл зэрэг баримтанд үндэслэн солонгосын боловсролын түвшин, гарал улс эсвэл гуравдагч улсад сурч байсан хугацаа, одоогийн боловсролын түвшин, өөрийн болон асран хамгаалагчийн хүсэл сонирхлыг нэгтгэн дүгнэж шийдвэр гаргадаг.
- Боловсролын түвшин тогтоох зөвлөл нь хүсэлт гаргагчийн сургалтын хөтөлбөрийг бүрэн ойлгон, хүлээн авах чадварыг шалгахын тулд шаардлагатай гэж үзвэл **ярилцлагын шалгалт** эсвэл түвшин **тогтоох бичгийн шалгалт авч болно**. Мөн зөвлөлийн шийдвэр гаргахад шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн байгууллагаас тусламж авч, **олон соёлт гэр бүлийн хүүхдийн сурах чадварыг** үнэлж болно. Гэвч, үнэлгээний дүн нь боловсролын түвшинг хүлээн зөвшөөрөх туйлын ганц хэмжүүр биш юм.

7) Иргэний бүртгэлийн лавлагаа, гадаадын иргэний бүртгэлийн лавлагаа зэргийг өөр ямар нэг бичиг баримтын бүрдүүлт хийлгүй сургууль болон хот, мужийн Боловсролын Газраас захиргааны мэдээлэл олгох албан портал(www.share.go.kr)-с шалгах боломжтой байдаг.

8) Сургуульд ирж очих хугацаа, унааны таатай нөхцөл болон бусад тойргийн нөхцөл байдлыг харгалзан сугалаагүй элсэн суралцах боломжтой хэмээн зарласан дунд сургууль

9) Оршин суугаа бүсийг хамарсан тойргийн бүс дэхь сургууль

III

БОЛОВСРОЛД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ ТОГТОЛЦОО



01

Олон соёлт гэр бүлийн хүүхдэд боловсрол олгох байгууллага



1 Олон соёлын боловсролын бодлого хэрэгжүүлэх сургууль

- Цэцэрлэг, бага · дунд · ахлах сургуулиудаас сонгон **Олон соёлын боловсролын бодлого хэрэгжүүлэх сургуулиар** итгэмжилж, сурагчдад олон соёлын тухай сургалт явуулж, олон соёлын тухай ойлголтыг хөгжүүлэх, олон соёлт гэр бүлийн хүүхдүүдэд зориулсан сургалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- **Олон соёлын тухай ойлголтыг хөгжүүлэх хөтөлбөр:** олон соёлын харилцан ойлголцол, нэг ертөнцийн иргэд сургалт, соёлын олон хэлбэр, өрөөсгөл үзэл · ялгаварлан гадуурхах үзлийн эсрэг сургалт
- **Олон соёлт гэр бүлийн хүүхдэд зориулсан хөтөлбөр:** хос хэлний сургалт, зөвлөгөө, давтлага өгөх хөтөлбөр(менторин) зэрэг байна.
- Олон соёлын боловсролын бодлого хэрэгжүүлэх сургуулийн тухай мэдээллийг харъяалах хот · мужийн Боловсролын Газараас лавлах юмуу **‘Олон соёлын боловсролын портал’** вэб хуудас(edu4mc.or.kr)–с авах боломжтой.

[Олон соёлын боловсролын бодлого хэрэгжүүлэх сургууль(Цэцэрлэг)]

- Олон соёлын боловсролын бодлого хэрэгжүүлэх сургуулийн нэг хэлбэр болох цэцэрлэгээс олон соёлт гэр бүлийн хүүхдүүдэд зориулсан сургалт(хэлний сургалт), түүнчлэн бүх цэцэрлэгийн хүүхдүүд–д олон соёлын тухай ойлголтыг хөгжүүлэх боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.
 - **Хэлний сургалт:** сургалтад хамрагдахын өмнөх · дараах хэлний чадварын үнэлгээ, бүлгийн болон ганцаарчилсан хэлний сургалт зэрэг
 - **Олон соёлын боловсрол:** Хүүхэд багачууд, багш сурган хүмүүжүүлэгч, эцэг эхчүүдэд олон соёлын тухай ойлголтыг нэмэгдүүлж, харилцан ойлголцолыг хөгжүүлэх зорилго бүхий хөтөлбөр зохион байгуулдаг.

[Олон соёлын боловсролын бодлого хэрэгжүүлэх сургууль (бага, дунд, ахлах)]

- Бага, дунд, ахлах сургууль хэлбэрийн олон соёлын боловсролын бодлого хэрэгжүүлэх сургуулиуд нь бүх насны сургуулийн сурагчдын ерөнхий боловсролын хөтөлбөртэй олон соёлын боловсролын хөтөлбөрийг уялдуулан холбож, олон соёлт гэр бүлийн хүүхдүүдэд чиглэсэн сургалтын хөтөлбөр боловсруулан ажилладаг.
 - **Олон соёлын боловсрол:** Хичээл сургалт болон бусад бүтээлч үйл ажиллагаа зэрэг хоорондоо уялдаа холбоо бүхий хөтөлбөр т тусгилэн олон соёлын тухай нийт сурагчдын ойлголтыг нэмэгдүүлнэ
 - **Олон соёлт гэр бүлийн хүүхдүүдэд чиглэсэн сургалт:** суурь сургалт болон мэргэжил сонгох тухай, зөвлөгөө өгөх, хос хэлний сургалт зэргийг зохион байгуулдаг.

[Солонгос хэлний анги(цэцэрлэг)]

- Элсэн орсон хүүхдүүдийн дийлэнх нь солонгос хэлээр ярьж чадахгүй гадаад хүүхдүүд бол, солонгос хэлний ангийг нээн ажиллуулж, тоглож байгаа тоглоомтой нь солонгос хэлийг уялдуулан холбож зааж, сургана.
- Олон соёлт гэр бүлийн хүүхдүүдийг солонгос амьдрал ахуй болон цэцэрлэгтээ хурдан дасан зохицож, үеийн хэнтэйгээ тоглож, харьцаж чадах хэмжээний солонгос хэлтэй болгох сургалт, амьдралын өдөр тутмын хэвшлийг төлөвшүүлэх сургалт зэргийг хамруулсан солонгосын соёлын тухай сургалтыг явуулдаг.

[Солонгос хэлний анги(бага, дунд сургууль)]

- Элсэн орсон сурагчдын дийлэнх нь гадаадад амьдарч байгаад ирсэн болон гадаад сурагчид бол, солонгос хэлний анги нээн ажиллуулна.
- Элсэн орсон гадаад сурагчдын хэл, соёлын онцлогийг харгалзан солонгосын амьдрал ахуй, сургуульдаа хурдан дасан зохицоход нь дэмжлэг болгож солонгос хэл, солонгос соёлын сургалтыг явуулдаг.
- Тухайн хүүхдийн суралцаж байгаа сургуульд нь солонгос хэлний анги хичээллэдэггүй бол зорин очиж солонгос хэл заах сургалтанд хамрагдаж болно. “Зорин очиж солонгос хэл заах сургалт” гэдэг нь энэ хөтөлбөрт хамрагдах шаардлагатай гэсэн сурагчдын суралцаж байгаа сургууль руу солонгос хэлний багш томилон ажиллуулдаг тогтолцоо юм.

7 Олон соёлын дүйцүүлэх боловсрол олгох сургууль

- Сургуулиас завсардсан, өөрийн онцлогтоо тохирсон сургалтанд хамрагдахыг хүсч буй олон соёлт гэр бүл ийн хүүхдэд чиглэсэн боловсролын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн дүйцүүлэх боловсрол олгох сургууль үйл ажиллагаа явуулдаг.
- Хот - мужийн Боловсролын Газараас итгэмжлэгдэн үйл ажиллагаа явуулж буй “боловсролын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн олон соёлын дүйцүүлэх боловсрол олгох сургууль” –н тухай мэдээллийг тухайн хот, мужийн н Боловсролын Газараас асууж лавлаж болно.

[Олон соёлт гэр бүлийн хүүхдэд чиглэсэн боловсролын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн дүйцүүлэх боловсрол олгох сургууль]

Сургуулийн нэр	Сургуулийн ангилал	Онцлог	Сургалтын төлбөр
Жигү Чун (дэлхий нэг тосгон) сургууль (Сүүл Гүрү-гү) globalsarang.com 02-6910-1004	Бага сургууль	<ul style="list-style-type: none"> • Солонгос, англи, хятад зэрэг хос хэлний сургалттай • Хичээлийн дараах сургалт, хүүхдийн онцлогт тохирсон төлбөргүй сургалттай • Нас тус бүрээр нэг анги хичээллэнэ • Насны ангилалгүй солонгос хэлний сургалтай анги 	Төлбөргүй ※ Хичээлийн дараах хөтөлбөр, хүүхдийн онцлогт тохирсон сургалт, хоолны мөнгө багтана
	Дунд сургууль	<ul style="list-style-type: none"> • Боловсролын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн дүйцүүлэх боловсрол олгох даалгавар хүлээсэн сургууль(тодорхой хугацаанд сургасны суралцах ёстой сургууль руу буцаана) 	
Сүүл Дасум аялал жуулчлалын ахлах сургууль (Сүүл Жүнрү-гү) sds.hs.kr 02-6743-0510	Ахлах сургууль (Мэргэжлийн боловсрол)	<ul style="list-style-type: none"> • Мэргэжил эзэмшүүлснээр ажилд орох боломжийг нэмэгдүүлэх төдийгүй солонгос хэл сурснаар нийгэмдээ дасан зохицон чадварыг нь дээшүүлнэ. • Ерөнхий боловсролын хичээл, мэргэжлийн үнэмлэхтэй болгоход чиглэсэн хичээл, сургалт явуулдаг • Олон соёлын хэлний багштай • Аялал жуулчлал, аялалын үйлчилгээ гэсэн ангилалтай • Бүрдүүлсэн материалын, ярилцлагын шалтгалтаар сонгон шалгарууна. 	Төлбөргүй ※ Сурагчийн дүрэмт хувцас, хоол төлбөртэй
Солонгосын Политехникийн Дасум ахлах сургууль (Чүнбүг Жэчон) kopo.ac.kr/dasom 043-649-2800	Ахлах сургууль (Мэргэжлийн боловсрол)	<ul style="list-style-type: none"> • Гадаад гэр бүлийн хүүхэд(Гадаадад амьдарч байгаад ирсэн хүүхэд)–д зориулсан техникийн сургалт • Сургуулийн бүх сурагчид дотуур байранд амьдарна – Бүс нутаг харгалза хгүй элсэн сурах боломжтой. • Үлсын Техникийн мэргэжлийн гэрчилгээ авах 100%-н боломжтой(1 хүн 1~8 мэргэжлийн гэрчилгээ авах боломжтой). • Төгсөгчдийн 80-с дээш хувь нь корпораци, төрийн өмчит байгууллагад ажилд орж, их дээд сургуульд элсдэг. • Солонгос хэлний түвшинд тохирсон сургалт, дугуйлан, UNESCO сургууль хичээллэдэг. <ul style="list-style-type: none"> – Тэнхим: Компьютер техникийн анги, Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн анги, Үхаалаг электрон техникийн ангитай. – Шалгаруулалт: Бичиг материал шалгаруулалтанд тэнцвэл ярилцлагын шалгалт (9сар, 12 сард) – Хөдөлмөрийн яамны харъяа Солонгосын Политехникийн Их сургуулиас удирдан ажиллуулдаг байгууллага юм. ※ Элсэлтийн тухай байнга зөвлөгөө өгдөг бөгөөд та хүссэн цагтаа сургууль дээр ирж сургуультай танилцаж болно. 	Төлбөргүй ※ Сургалт, дотуур байр, хоол, зууш, хичээлийн дараах хөтөлбөрийн үнэ багтсан
Инчон Хан-Нүри сургууль (Инчон Намдун-гү) hannuri.icesc.kr 032-627-2250	Бага-дунд ахлах нэгдсэн сургууль	<ul style="list-style-type: none"> • Бүс нутаг харгалзахгүй элсэлт авдаг боловсролын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн дүйцүүлэх боловсрол олгох даалгавар хүлээсэн сургууль(тодорхой хугацаанд сургасны суралцах ёстой сургууль руу буцаана: бага сургууль 6 сар, дунд, ахлах сургууль 1 жил байна) • Орон нутгийн өмчит сургуулийн үндсэн багш нар заадаг • Хэл тус бүрээр хос хэлний багштай(хятад, орос, вьетнам, араб хэлний зэрэг) • Бага, дунд, ахлах сургуулийн солонгос хэлний багш нартай • Солонгос хэлний түвшин тус бүрээр анги хичээллэдэг • Дотуур байртай(даваа-баасан; бага сургуулийн 5-с дээш анги боломжтой) • Сургуулийн автобусаар үйлчилнэ(Инчон дотор) 	Бүрэн Төлбөргүй
Хэмил сургууль (Канвон-ду Хунчон) haemillschool.gwe.ms.kr 033-433-8761	Дунд сургууль	<ul style="list-style-type: none"> • Олон соёлт гэр бүл төвтэй боловсролын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн дүйцүүлэх боловсрол олгох даалгавар хүлээсэн сургууль • Дотуур байртай жижиг сургууль(Анги тус бүр 20 хүүхэдтэй) • Олон соёлт гэр бүлийн хүүхдийг хамруулан бүх сурагчдад нэгдсэн сургалт • Насны ялгалгүй түвшинд нь тохирсон сургалт • Гадаадад амьдарч байгаад ирсэн хүүхдэд зориулсан солонгос хэлний ангитай • Хос хэлний сургалт(Хятад, япон, вьетнам хэл) • Хэмил сургуулийн нийт сурагчдын хурал зэрэг сурагчдын бие даасан ажиллагааг удирдан дэмждэг • Гадаад, дотоодын ажил мэргэжилтэй танилцах, хилийн чанад дахь сайн санааны аянд оролцох 	Төлбөргүй ※ Сургалт, дотуур

※ Хоол, байр, дүрэмт хувцас, төрөл бүрийн хөтөлбөрт оролцох төлбөр зэрэг нь тухайн орон нутаг, сургууль бүрт өөр өөр байж болно.

1 Гадаад иргэдийн сургууль

- Гадаад иргэдийн сургууль нь гадаад иргэдийн хүүхэд болон 3 жилээс дээш хугацаагаар гадаадад амьдарч байгаад эргэж ирсэн солонгос хүүхэд, солонгос хэлний мэдлэггүйн улмаас энгийн сургуульд сурах бол омжгүй солонгос иргэншил авсан хүүхдэд боловсрол олгодог байгууллага юм.
- Эцэг эх нь хоёулаа юмуу аль нэг нь гадаад улсын иргэн бол хүүхэд нь гадаад иргэдийн сургуульд элсэн суралцах боломжтой. Тухайн сургуулийн үйл ажиллагааны онцлогоос хамаараад элсэлтийн журам нь сургууль бүрт өөр байж болох боловч ерөнхийдөө жилийн туршид бүртгүүлэх боломжтой байдаг.
- ‘Гадаад улсын боловсролын байгууллага, Гадаад иргэдийн сургуулийн нэгдсэн танилцуулга’ вэб хуудас (www.isi.go.kr)-с сургуулиудын элсэлтийн журам, сургалтын төлбөрийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой.

02 Олон соёлт гэр бүлийн хүүхдийн боловсролд үзүүлэх дэмжлэг



1 Олон соёлт гэр бүлийн хүүхдэд үзүүлэх менторинг үйлчилгээ

- Олон соёлт гэр бүлийн хүүхдэд үзүүлэх менторинг үйлчилгээ гэдэг нь нэг оюутан олон соёлт гэр бүлийн нэг хүүхдийг даан авч бага дунд ахлах сургуульд дасан зохицоход нь мөн суурь боловсрол, мэдлэгээ дээшлүүлэн суралцах чадвараа нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлдэг хөтөлбөр юм. Үүнд хамрагдахын тулд сургууль болон бүсийн хүүхдийн төвөөр дамжуулан хүсэлт гаргаж болно.
- Ментор оюутан олон соёлт гэр бүлийн хүүхдийн сурч байгаа сургууль дээр очин хичээлийн дараа эсвэл сургуулийн амралтын үеэр хичээл давтлагат нь тусална. Долоо хоногт 20 цаг(сургуулийн амралтын үеэр долоо хоногт 40 цаг) орчим менторинг авах боломжтой.

03 Сургалтын төлбөрт үзүүлэх дэмжлэг



1 3~5 насны хүүхдэд үзүүлэх дэмжлэг

- Эцэг эхийн орлогын түвшингээс үл хамааран 3~5 насны бүх хүүхдийн цэцэрлэгийн төлбөрийн дэмжлэг үзүүлдэг.
※ БНСУ-ын иргэншил аваагүй бол тэтгэлэгт хамаарагдахгүй(хэрэв эцэг эх нь дүрвэгч бол тэтгэлэг зөвшөөрөгдөнө)
- Эцэг эх(асран хамгаалагч) нь оршин суугаа газрыг харъяалах баг/сум/хорооны захиргаан дээр биеэр очих юмуу интернетээр нийгмийн халамжийн (online.bokjiro.go.kr) веб хуудас руу нэвтэрч бүртгүүлэх боломжтой.

2 Бага орлоготой өрхийн бага насны хүүхдэд сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх

- Бага насны хүүхдийн сургалтын төлбөрт дэмжлэг авах болзлыг хангасан* бөгөөд хувийн цэцэрлэгт явдаг, хуульд заасан бага орлоготой өрх(амьжиргааны доод түвшингийн тэтгэмж авдаг өрх, нэн ядуу өрх, хүүхдээ ганцаараа өсгөдөг эх, эцэг)-н бага насны хүүхдэд сар бүр 100 мянга хүртэл хэмжээний нэмэлт тэтгэмж олгож, дэмжлэг үзүүлнэ. Эцэг эхийн орлогын түвшингээс үл хамааран 3~5 насны бүх хүүхдийн цэцэрлэгийн төлбөрт дэмжлэг үзүүлдэг.

* Сургуульд анх элсэх, сургуульд орох зэрэг тохиолдол мөн үүнд хамаарна.

- Эцэг эх(асран хамгаалагч) нь оршин суугаа хаягийнхаа дагуу харъяалах тасаг/баг/хорооны захиргаан дээр биеэр очиж хүсэлт гаргах боломжтой.

3 Бага орлоготой өрхийн хүүхдэд сургалтын төлбөр · тэтгэмжийн дэмжлэг үзүүлэх

- Бага орлоготой өрхийн хүүхдийн ахлах сургуулийн төлбөр, сургуулийн хоолны мөнгө зэрэг “Сургалтын зардал” болон сурах бичиг, хичээлийн хэрэгслийн зардалд дэмжлэг үзүүлэх “Сургалтын тэтгэмж”-ийн тогтолцоо байдаг. Үүнд хамрагдахын тулд эцэг эх(асран хамгаалагч) нь оршин суугаа хаягийнхаа дагуу харъяалах тасаг/баг/хорооны захиргаан дээр өөрийн биеэр очиж бүртгүүлнэ.
- Сургалтын төлбөрийн дэмжлэг авахын тулд Сургалтын төлбөрийн One click бүртгэл(oneclick.moe.go.kr) болон нийгмийн халамжийн вэб хуудас(online.bokjiro.go.kr)-д нэвтэрч бүртгүүлнэ(Албан баталгаажуулалт шаардлагатай).

Q TIP School Banking

► Заавал эзэмших боловсролд хамаарах бага, дунд сургуулийн сургалт(элсэлтийн хураамж, хичээлийн төлбөр зэрэг) үнэ төлбөргүй байдаг. Харин хоол, танилцах аялал сургалт, хичээлийн дараах сургалтын төлбөрийг эцэг эх нь хариуцана. Бага · дунд · ахлах сургуульд төлөх төрөл бүрийн төлбөрийн мөнгийг шилжүүлэхдээ сургуулийн нэрийн дан с руу тодорхой хугацаа бүрт автоматаар данснаас авдаг School Banking системийг ашиглах нь хялбар байдаг.

04 СҮРГҮҮЛЬД СУРАХАД ҮЗҮҮЛЭХ ДЭМЖЛЭГ



➤ Wee class(Сургуулийн зөвлөгөө өгөх төв)

- Сургууль дотор үйл ажиллагаа явуулдаг Wee class зөвлөгөө өгөх төв нь хүнтэй харилцах чадвар сул, сургуулийн хүчирхийлэлд өртсөн, бусдад уруу татагдах зэрэг төрөл бүрийн шалтгаанаар хичээл сургуульдаа явахад нь асуудал тулгарсан хүүхдэд зөвлөгөө өгч тусалдаг.
- Таны хүүхдийн явдаг сургуульд Wee class байхгүй бол тухайн сургуулийн харъяалагдах Боловсролыг Дэмжих Газарын Wee төвд хандан үүний адил үйлчилгээ авах боломжтой.

➤ Wee төв(Хот, мужийн Боловсролыг Дэмжих Газарын сурагчдад зөвлөгөө өгөх төв)

- Wee төв нь сургуулийн зүгээс засаж залж, эмчлэхэд ярвигтай байдалд орсон сурагчид туслах зорилгоор Боловсролыг Дэмжих Газараас байгуулсан зөвлөгөө өгөх байгууллагын хувьд сургууль дээр шийдвэрлэж чадаагүй асуудлыг шийдвэрлэж, зөвлөгөө өгөх үйлчилгээ, тусгай сургалт явуулан, хүүхдийг сургууль завсардахаас сэргийлэх зэрэг төрөл бүрийн ганцаарчилсан хөтөлбөр ажиллуулна.
- Бага · дунд · ахлах сургуулийн сурагчид бүгд Wee төвөөр үнэ төлбөргүй үйлчлүүлэх боломжтой. Wee төв дээр ирэхдээ сургуульдаа урьдчилан хэлж ирвэл хичээлд суусанд тооцдог.

➤ Wee school(Хот · мужийн Боловсролын Газар)

- Аюултай байдалд орсны улмаас урт хугацааны эмчилгээ · хөтөлбөрт хамрагдах шаардлагатай, сургууль завсардсан хүүхдийг хот · мужийн Боловсролын Газараас байгуулсан Wee school-ийн дотуур байртай дүйцүүлэх боловсрол олгох сургуулийн хөтөлбөрт болон бусад даалгавар хүлээсэн сургуулийн сургалт, үйлчилгээнд хамруулах боломжтой.

➤ Сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг арга хэмжээ авах зөвлөл

- Бүх сургуульд сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг арга хэмжээ авах зөвлөл ажилладаг. Тус зөвлөл нь сургуулийн орчинд хүчирхийлэл үүсэхээс сэргийлэх, түүнд авах арга хэмжээг боловсруулах, хүчирхийлэлд өртсөн сурагч, хохирол учруулсан сурагчдын маргааныг зохицуулах зэрэг сургуулийн орчин дахь хүчирхийлэлтэй холбоотой хэргийг шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг.
- Хэрвээ таны хүүхэд сургуулийн орчин дахь хүчирхийлэлд өртсөн бол анги удирдсан багшаар нь дамжуулан сургуулийн орчин дахь хүчирхийллийн асуудал хариуцсан байгууллагад мэдэгдэнэ. Мөн эцэг эх(асран хамгаалагч) нь өөрийн биеэр сургуулийн захиргаанд хүсэлт гарган сургуулийн орчин дахь хүчирхийллийн эсрэг арга хэмжээ авах зөвлөлийг хуралдуулах боломжтой.

Q TIP Сургуулийн орчинд хүчирхийлэлд өртсөн үед авах арга хэмжээ

- Сургуулийн орчин дахь хүчирхийлэл гэдэг нь сургуулийн дотоод болон гадаад орчинд зодуулж бэртэх, хүчирхийлэлд өртөх, хоригдох, сүрдүүлэгт өртөх, мансууруулах бодис хүчээр хэрэглэх · бусдад уруу татагдах, нэр хүндээ гутаалгах, сүрдүүлж худал хэлүүлэх, албадан · хүч хэрэглэн зарах, бэлгийн хүчирхийлэл, гадуурхагдах, мэдээллийн сүлжээнд садар самуун · хүчирхийллийн чанартай мэдээлэлд өртөж бие болон оюун санаа, эд хөрөнгийн хохирол учруулгах үйлдлийг хэлнэ. “Шалихгүй дээрэлхэл биз” хүүхдүүдийн “тоглоом” биз гэж өнгөрөөсөн үйлдэл ч сургуулийн орчинд хүчирхийлэл болж болно.
- Хэрвээ таны хүүхэд хүчирхийлэлд өртсөн бол даруй анги даасан багштай нь уулзах цаг болжой, хүчирхийлэлд өртсөн нөхцөл байдлын тухай тайлбарлана. Өөр тусламж шаардлагатай бол сургуулийн орчин дахь хүчирхийллийг мэдэх төвийн утас ☎117 (Гар утаснаас залгахдаа орон нутгийн дугаар+117)-д хандаж яаралтай тусламж, хамгаалалт хүсэх юмуу зөвлөгөө өгөх шуурхай үйлчилгээ авах боломжтой.

Хавсралт 1

「Солонгос улсын боловсролын тогтолцоо, анги дэвшин суралцах тухай мэдээлэл」 эцэг эхчүүдэд зориулсан видео материал



- » 「Солонгос улсын боловсролын тогтолцоо, анги дэвшин суралцах тухай」 видео киног сургуулийн өмнөх насны болон бага сургуулийн насны хүүхэдтэй олон соёлт гэр бүлийн эцэг эхчүүдэд зориулан сургуулийн тухай мэдээллийг хялбар ойлгохоор 6 бүлэг(бүлэг тус бүр ойролцоогоор 20 минут)–т багтаан хийсэн.
- » Солонгос улсын боловсролын тогтолцоо болон бага сургуульд элсэн орохоос эхлээд сургууль төгсөх хүртэлх хугацаанд эцэг эхчүүдийн мэдэж байх шаардлагатай мэдээллийг өгнө. Энэхүү видео материалыг олон соёлын боловсролын портал сайт(edu4mc.or.kr), Prime College Hub University(hub.knou.ac.kr), олон соёлт гэр бүлийг дэмжих портал Танүри(liveinkorea.kr) зэрэг вэб сайтнаас үзэх боломжтой.
- » Видео кино солонгос хэл дээр хийгдсэн бөгөөд 5 орны(Орос, Вьетнам, Англи, Япон, Хятад) хэлээр хадмал орчуулгыг сонгон үзэх боломжтой.

Бүлэг	Бүлгийн нэр	Үндсэн түлхүүр үг	Бичлэг
1	Та солонгос сургуулийн тухай мэдэхийг хүсч байна уу?	Ясли, цэцэрлэг, ерөнхий боловсрол, дээд боловсрол олгох байгууллага, заавал эзэмших боловсрол	
2	Бага сургуульд орохын өмнө юу бэлдэх ёстой вэ?	Сургуульд орох мэдэгдлийн хуудас, чиглүүлэх сургалт явагдах өдөр, хүүхэд саатуулах анги, хичээлийн дараах сургалт, эцэг эхтэй харилцах дэвтэр	
3	Та бага сургуулийн хичээлийн өдрийн хуваарь, 1 жилийн хөтөлбөртэй танилцах уу?	Сургуулийн үндсэн үйл ажиллагаа, орох хичээл, хичээлийн цаг, үдийн цаг, дадлага сургалт, зуны амралт, биеийн тамирын өдөрлөг, богино хугацааны амралт	
4	Бага сургуулийн хүүхдийг хэрхэн сурган хүмүүжүүлэх вэ?	Ахуйн хүмүүжил, шаардлагатай хичээлийн хэрэгсэл, эцэг эхтэй харилцах дэвтэр, сургуульдаа аюулгүй ирж очих, ослоос урьдчилан сэргийлэх	
5	Хүүхдийн гэрийн даалгавар, хичээлийг хэрхэн зааж өгөх вэ?	Хичээл зааж өгөх, гэрийн даалгавар, цээж бичиг, өдрийн тэмдэглэл, ном унших, гүйцэтгэлийн үнэлгээ	
6	Бага сургуулиа төгсөхөөр нь яах вэ? (Хүүхдийн хүсэл мөрөөдөл анги дэвшин суралцах)	Бага сургууль төгссөний дараа хийх ёстой зүйлс, хүүхдийн үр чадвар занхарактер, анги дэвшин сурах, ирээдүйн хүсэл мөрөөдөл, мэргэжил, үр чадварын гэрчилгээ, олж авсан мэдээлэл	



[Цэцэрлэгт хэрэглэгддэг үг хэллэг(Үлгэрчилсэн загвар)]

Үг хэллэг	Үндсэн агуулга
Цэцэрлэгийн хүүхэд (원아)	Цэцэрлэгт явдаг хүүхдийг хэлнэ. Хүүхэд 3 наснаас бага сургууль(ихэвчлэн 5 нас хүртэлх хүүхэд)-д ортлоо цэцэрлэгт явдаг.
Хүүхдийн эцэг эх (학부모)	Цэцэрлэгийн хүүхдийн аав, ээж зэрэг асран хамгаалагчийг хэлнэ.
Цэцэрлэгтээ явах (학부모)	Цэцэрлэгийн хүүхэд цэцэрлэг дээрээ очин сургалтын үйл ажиллагаанд оролцож эхлэхийг хэлнэ
Цэцэрлэгээсээ ирэх (하원)	Хүүхэд цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагааг дуусгаад гэр лүүгээ буцаж явахыг хэлнэ
Тоглоом тоглох (놀이)	Тоглоом тоглох гэдэг нь цэцэрлэгийн танхим дотор(өрөх, ямар нэг хүний дүрд тоглох, дуу дуулах, хэл яриа, шинжлэх ухаан танин мэдэхүйн, зураг зурах зэрэг) болон гадаа(хөдөлгөөнт тоглоомон дээр тоглох, гүйж хөдлөх, ус, элсээр тоглох, байгальтай танилцах зэрэг) наа дахыг хэлэх бөгөөд заримдаа дотор, гадаа хослуулан чөлөөтэй тоглож нааддаг.
Үдийн цай (급식)	Цэцэрлэгээс хүүхдэд өгдөг үдийн цай
Эцэг эхтэй харилцах дэвтэр (가정통신문)	Цэцэрлэгийн сургалтын ажил, эцэг эхчүүдэд зориулсан сургалт, хүүхдийн хичээл сургалтын тухай мэдээллийг бичиж тэмдэглэсэн дэвтэр
Хичээлийн дараах хөтөлбөр (방과후 과정)	Цэцэрлэгийн хичээлийн дараа явагддаг хичээлээс гадуурх хөтөлбөр болон хүүхэд харах хөтөлбөр багтана.
Өглөө, орой, бүтэн өдөр хүүхэд харах (아침, 저녁, 온종일 돌봄)	Эцэг эх нь хоёулаа ажил хийдэг, ганцаараа хүүхдээ өсгөдөг гэр бүлийнхэн зэрэг хүүхдээ харуулах шаардлагатай хүмүүст зориулсан хөтөлбөр
Хичээлийн дараах хөтөлбөрийн багш (방과후 교사)	Сургалт хүмүүжлийн ажлын дараа хийгдэх ажил хөтөлбөрийг хариуцсан багш
Цэцэрлэгийн дарга (원장)	Цэцэрлэгийн үйл ажиллагааг ерөнхийд нь хариуцдаг удирдах ажилтан
Цэцэрлэгийн эрхлэгч (원감)	Цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулахад цэцэрлэгийн даргад туслан албан хэргийг явуулдаг удирдах ажилтан
Багшийн үр чадвар, хөгжүүлэлтийн үнэлгээ (Эцэг эхийн сэтгэл ханамжийн судалгаа) (교원능력개발평가 (학부모만족도조사))	Сэтгэл ханамжийн онлайн судалгаа явуулан анги даасан багш, хичээлийн эрхлэгч, цэцэрлэгийн даргын ажлыг үнэлдэг
Цэцэрлэгийн удирдах зөвлөл (유치원운영위원회)	Цэцэрлэгийн багш, төлөөлөгч, эцэг эхийн төлөөллийн бүрэлдэхүүн бүхий баг сургалтын үйл ажиллагааны үндсэн асуудлуудыг хянаж · зөвлөгөө өгдөг
Цэцэрлэгийн төлбөр (원비)	Сургалт хүмүүжлийн ажлыг явуулахын тулд цэцэрлэгт төлдөг сургалтын төлбөр
Захиргаа (행정실)	Цэцэрлэгийн төлбөр, дадлага ажлын төлбөр, цэцэрлэгийн орлого · зарлагатай холбогдох санхүүгийн албан хэргийг хариуцсан алба



[Цэцэрлэгт хэрэглэгддэг үг хэллэг(Үлгэрчилсэн загвар)]

Үг хэллэг	Үндсэн агуулга
School Banking (스쿨뱅킹)	(School Banking) Эцэг эхийн нэрийн данснаас сургалтын төлбөр(танилцах сургалтын төлбөр эзрэг)-г цэцэрлэгийн данс руу автоматаар шилжүүлдэг тогтолцоо
Цэцэрлэгийн хүүхдийн бүртгэл (유아 모집)	Цэцэрлэгийн бүртгэл хүүхэд цэцэрлэгт оруулах өргөдлийн анкет бөглөж бүртгүүлэх, түүвэр сугалаа явуулах, элсэгчийн бүртгэл явуулах аргын дагуу явагдана
Чиглүүлэх сургалт (오리엔테이션)	(Orientation) Шинээр элсэх хүүхдийн эцэг эхчүүдэд цэцэрлэгийн сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа, сургалтын хөтөлбөр зэргийг танилцуулах өдөрлөг
Хичээлийн шинэ жилийн нээлт (입학식)	Цэцэрлэгт орж байгаа хүүхдүүдийг цуглуулан хичээлийн шинэ жилийн нээлт хийх ёслол
Танилцах дадлага сургалт (현장체험학습)	Сургалтанд шаардлагатай материал бүхий газар дээр очиж ажиглалт · дадлага сургалт хийх
Биеийн тамирын өдөрлөг (운동회)	Эцэг эхчүүд, хүүхдүүд хамтдаа цуглаж биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулдаг өдөрлөг
Хүүхдийн эцэг эхэд өгөх зөвлөгөө (학부모상담)	Эцэг эхчүүд хүүхдийнхээ анги даасан багштай нүүр тулан уулзаж хүүхдийнхээ сургалт хүмүүжлийн ажилд оролцож байгаа байдал, үүссэн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар ярилцах
Эцэг эхийн оролцох нээлттэй хичээл (학부모 공개수업)	Эцэг эхчүүдийг цэцэрлэг дээр урин ирүүлж нээлттэй хичээл явуулдаг өдөр
Хичээлийн амралт (방학)	Хичээлийн жил, улирлын эцэст цэцэрлэг тодорхой хугацаагаар амарна. Мөн халууны улиралд зуны амралт, хүйтний улиралд өвлийн амралт гэж амарна(Зуны, өвлийн, хаврын амралт зэрэг)
Хичээлийн нээлт (개학식)	Цэцэрлэгийн амралт дуусч хичээл дахин эхлэхэд хийдэг ёслол
Цэцэрлэг байгуулагдсаны ойн баярын өдөр (개원기념일)	Бүх цэцэрлэгүүд жил бүр байгуулагдсаныхаа ойн баярын өдрийг тохиолдуулан нэг өдөр амардаг
Цэцэрлэгээс тогтоосон амралтын өдөр (재량휴업일)	Цэцэрлэгээс амралтын өдрийг тогтоож хүүхдүүдийг нэг өдөр болон тодорхой хугацаагаар амрах өдөр
Төгсөлтийн баяр (졸업식)	Цэцэрлэгийн хүүхэд холбогдох журмын дагуу зохих сургалтыг дүүргэн, төгссөнийг нотлох гэрчилгээ хүлээн олгох ёслол. Үүнд 5 настай хүүхдүүд хамрагдана
Анги төгсөх баяр (수료식)	Хүүхэд цэцэрлэгийн нэг жилийн сургалтанд хамрагдаж дүүргэхэд явагддаг ёслол. Үүнд 3,4 настай хүүхдүүд хамрагдана

※ Дээрхи үг хэллэг нь тухайн орон нутаг, цэцэрлэгийн үйл ажиллагааны онцлогоос хамаараад өөр байж болно.



[Бага сургуульд хэрэглэгддэг үг хэллэг (Үлгэрчилсэн загвар)]

Үг хэллэг	Үндсэн агуулга
Долоо хоног (주간)	Даваагаас Ням гараг хүртэлх нэг долоо хоногийн хугацаа
Хичээлийн улирал (학기)	Хичээлийн нэг жилийг сургалтын үйл ажиллагааны шаардлагад нийцүүлэн хуваасан хугацаа. Ихэвчлэн 3-8 сар болон 9-2 сарын хугацаагаар 2 улиралд хуваадаг
Сургуульд шилжин суралцах (전학)	Сурч байгаа сургуулиасаа гарч өөр сургуульд шилжин суралцах
Сурагчийн хувийн хэрэг (학교생활기록부)	Сурагчийн сургуульд суралцсан байдал, физиологи*сэтгэц*зан байдал*нийгмийн хөгжил төлөвшлийн онцлогийг хөтөлсөн баримт
Суралцсан байдлыг мэдээлэх хуудас (생활통지부)	Сурагчийн сургуульд суралцаж байгаа бүх байдал(Хичээлд суусан байдал, суралцах чадварын хөгжил зэрэг)-г хөтөлсөн баримтыг улирлын эцсээр тараадаг
Хичээлд суугаагүй цагийг сууснаар тооцох (출석인정결석)	Гэр бүлийн гишүүний хурим, оршуулга, хуулинд заасан халдварт өвчин, гэр бүлийн танилцах аялалд оролцсоны улмаас тасалсан хичээлийг сууснаар тооцно.
Харилцах дэвтэр (알림장)	Хүүхдийн анги даасан багш сургууль, ангиас мэдээлэх зүйлсийг дэвтэр дээр бичиж эцэг эхэд дамжуулах
Эцэг эхтэй харилцах дэвтэр (가정통신문)	Сургуулиас эцэг эхэд сургуулийн сургалт хүмүүжлийн ажлын төрөл бүрийн үйл ажиллагаа, мэдээ хүргэх дэвтэр
Долоо хоногийн хичээлийн хуваарийн дэвтэр (주간학습 안내장)	Долоо хоногийн хичээлийн цагийн хуваарь, бэлдэх зүйлс, ангийн ажил, анги даасан багшаас дамжуулах мэдээг тэмдэглэсэн дэвтэр
Гүйцэтгэлийн үнэлгээ (수행평가)	Сурагчийн мэдлэг, чадвар, хичээл ойлгон хүлээн авч байгаа байдлыг шалгахын тулд хүүхдийн хийсэн бүтээл, ажил гүйцэтгэлийн явцыг төрөл бүрийн арга(зохион бичлэг, яриа-хэлэлцүүлэг, туршилт-дадлаг а, ажиглалт, өөрийн-ангийн хүүхдийн үнэлгээ)-р үнэлэх арга
Хувийн мэдээлэл ашиглах зөвшөөрлийн бичиг (개인정보활용동의서)	Сургуулийн сургалтын үйл ажиллагаанд хүүхдийн хувийн мэдээллийг ашиглахын тулд эцэг эхээс авдаг зөвшөөрлийн бичиг
Хичээлийн дараах сургалт (방과후교실)	Албан сургалт хүмүүжлийн ажлын дараа явагддаг төрөл бүрийн сургалтын хөтөлбөр
Эрүүл мэндийн үзлэг (건강검진)	1 · 4 дүгээр ангийн сурагчид сургуулиас нэр заасан эмнэлэг дээр очиж хамрагдах эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх үзлэг
Амны хөндийн эрүүл мэндийн үзлэг (구강검진)	2 · 3 · 5 · 6 дугаар ангийн сурагчид сургуулиас нэр заасан шүдний эмнэлэг дээр очиж хамрагдах амны хөндийн эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх үзлэг
Биеийн хөгжлийн үзлэг (신체발달검사)	Хүүхдийн биеийн өндөр, жин зэргийг тодорхойлон хүүхдийн биеийн хөгжил, эрүүл мэндийг шалгах үзлэг
Номын сангийн үнэмлэх (도서 대출증)	Сургуулийн номын сангаас ном зээлэхэд ашигладаг үнэмлэх
Сургуулийн удирдах зөвлөл (학교운영위원회)	Сургуулийн багш, хүүхдийн эцэг эх, бүс нутгийн нийгмийн байгууллагын төлөөлөл бүхий зөвлөл сургуулийн үйл ажиллагаа, сургалт хүмүүжлийн ажилд хяналт тавьж, зөвлөгөө өгдөг
Сургуулийн цагдаа (학교전담경찰관)	Сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор хүүхэд · эцэг эхчүүдийг сургалтад хамруулж, сургуулийн орчны хүчирхийллийг таслан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй сургуулийн цагдаагийн албан хаагч



[Бага сургуульд хэрэглэгддэг үг хэллэг (Үлгэрчилсэн загвар)]

Үг хэллэг	Үндсэн агуулга
Хичээлийн шинэ жилийн нээлт (입학식)	Бага сургуулийн 1 дүгээр ангид шинээр элсэгчдийг цуглуулан зохион байгуулдаг ёслол
Ангийн зөвлөлийн гишүүдийн сонгууль (학급 임원선거)	Анги тус бүрийн анги төлөөлөх сурагч(ангийн дарга, орлогч)–г сонгох ажил
Сургуулийн сурагчдын зөвлөлийн гишүүдийн сонгууль (전교어린이임원선거)	Сургууль тус бүр сургуулиа төлөөлөх сурагчид(сургуулийн сурагчдын зөвлөлийн дарга, орлогч)–н төлөөллийг сонгох ажил
Танилцах дадлага сургалт (현장체험학습)	Сургуулийн сургалт хүмүүжлийн ажлын төлөвлөгөөний дагуу сургалтад шаардлагатай материал бүхий газар очиж танилцуулах сургалт хүмүүжлийн ажил(Жиш: хавар, намрын дадлага сургалт, танин мэдэхүйн)
Хичээлээс гадуурхи дадлага сургалт (교외체험학습)	Сургуулийн захирлын зөвшөөрөлтэйгээр хувиараа танилцах сургалт, соёлын дадлага сургалт, ажил мэргэжилтэй танилцах аялал зэрэг сургалт хүмүүжлийн ажил(Жиш: Соёлын танилцах аялал, сургалт, даалгаварт аялал, гэр бүлийн аялал, хамаатныдаа зочлох, эмээ өвөөдөө туслах ажил зэрэг)
Биеийн тамирын өдөрлөг (운동회)	Сургуулийн сурагчдын дунд биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах ажил
Танилцах аялал (수학여행)	Сурагчид анги даасан багшийнхаа удирдлагын дор байгаль, соёлын өвийг өөрийн нүдээр харж судалж танилцах аялал
Байгаль дахь сургалтын ажил (야영수련활동)	Үүл ус, далай зэрэг байгалийн орчинд хүүхдэд бие балдар, сэтгэлийн хат суулгах ажил
Сургууль байгуулагдсаны ойн баярын өдөр (개교기념일)	Бүх сургуулиуд жил бүр байгуулагдсанхаа ойн баярын өдрийг тохиолдуулан нэг өдөр амардаг
Сургуулиас тогтоосон амралтын өдөр (재량휴업일)	Сургуулиас амралтын өдрийг тогтоож сурагчдыг нэг өдөр болон тодорхой хугацаагаар амраадаг өдөр
Эцэг эхийн хурал (학부모 총회)	Сурагчдын эцэг эхчүүдийг цуглуулан сургуулийн сургалт хүмүүжлийн ажилтай танилцуулан, сургуулийн үйл ажиллагааны тухай хэлэлцүүлэх(сургалт хүмүүжлийн ажлын тайлан хурал)
Хүүхдийн эцэг эхэд өгөх зөвлөгөө (학부모 상담)	Эцэг эхчүүд болон багш хамтран хүүхдэд тулгарсан асуудлыг шийдвэрлэх, хүүхдийн талаар мэдэхийг хүссэн зүйлсийн талаар ярилцах
Эцэг эхийн оролцох нээлттэй хичээл (학부모 공개수업)	Эцэг эхчүүдийг сургууль дээр урин ирүүлж нээлттэй хичээл явуулдаг өдөр
Хичээлийн амралт (방학)	Хичээлийн жил, улирлын эцэст сургуулийн хичээлийг тодорхой хугацаагаар амраадаг. Халууны улир алд зуны амралт, хүйтний улиралд өвлийн амралт гэж амраана(Зуны, өвлийн, хаврын амралт зэрэг)
Хичээлийн нээлт (개학식)	Сургуулийн хичээлийн амралт дуусч хичээл дахин эхлэхэд хийдэг ёслол
Эрдэм мэдлэг, урлагийн үзлэг (학예회)	Сургуульд дээр зохион байгуулагддаг зургийн үзэсгэлэн, уран илтгэлийн тэмцээн, урлагийн үзлэг зэрэг сургалт хүмүүжлийн ажил
Анги төгсөх баяр (종업식)	Сургуулийн хичээлийн нэг жилийн сургалт хүмүүжлийн ажил дуусахад хийдэг ёслол
Төгсөлтийн баяр (졸업식)	Бага сургуулийн 6 жилийн сургалтыг дүүргэснийг нотлох гэрчилгээ олгох ёслол

※ Дээрхи үг хэллэг нь тухайн орон нутаг, бага сургуулийн үйл ажиллагааны онцлогоос хамаараад өөр байж болно.



[Дунд · ахлах сургуульд хэрэглэгддэг үг хэллэг (Үлгэрчилсэн загвар)]

Үг хэллэг	Үндсэн агуулга
Хичээлийн нэрс (교과)	Сургуульд орох хичээлийн нэрс
Сурах бичиг (교과서)	Хичээл тус бүр дээр хэрэглэх ном
Бүтээлч ажил үйлс (창의적 체험활동)	Хичээлээс гадуурхи чөлөөт ажил, дугуйлан, сайн санааны ажил, ирээдүйн мэргэжил сонгох гэс эн 4 хэсгээс бүрдэнэ
Сурагчийн хувийн хэрэг (학교생활기록부)	Сурагчийн сургуульд суралцсан байдал, физиологи•сэтгэц•зан байдал•нийгмийн хөгжил төлөв шил, онцлогийгхөтөлсөн баримт
Голч дүн (내신)	Сургуульд суралцах хугацааны дундаж дүн(Шалгалтын дүн, бие дааж гүйцэтгэх ажлын үнэлгээ, бичгийн ажлын үнэлгээ зэрэг)
Гүйцэтгэлийн үнэлгээ (수행평가)	Хүүхдийн мэдлэг, чадвар, хичээл ойлгон хүлээн авч байгаа байдлыг шалгахын тулд хүүхдийн хийсэн бүтээл, ажил гүйцэтгэлийн явцыг төрөл бүрийн арга(зохион бичлэг, яриа · хэлэлцүүлэг, туршилт · дадлага, ажиглалт, өөрийн · ангийн хүүхдийн үнэлгээ)–аар үнэлэх арга
Үр чадварын шалгалт (실기)	Дүрслэх урлаг, дуу хөгжим, биеийн тамирын хичээлийн зураг зурах, хөгжим тоглох, холын зай ны үсрэлт, гүйлт зэрэг үүрэг даалгаврыг гүйцэтгүүлэх шалгалтыг хэлнэ
Англи хэлний сонсох чадварын үнэлгээ (영어듣기평가)	Нийт орон нутгийн хэмжээнд 17 хот· мужийн Боловсролын Газар хамтран зохион байгуулдаг англи хэлний сонсох чадварын үнэлгээний шалгалт. Жил тутамд 2 удаа явагддаг бөгөөд англи хэ лний хичээлийн бие даалтын ажлын үнэлгээнд оруулах тохиолдол ч байдаг.
Явцын шалгалт (중간고사)	Хичээлийн улирлын явцад авдаг шалгалт
Улирлын эцсийн шалгалт (기말고사)	Хичээлийн улирлын эцэст авдаг шалгалт
Элсэлтийн загвар шалгалт (모의고사)	Их, дээд сургуулийн элсэлтийн шалгалтанд бэлтгэх зорилгоор урьдчилан өгдөг шалгалтын заг варын хэлбэр бөгөөд үүнийг сургуулийн голч дүнд оруулдаггүй
Элсэлтийн шалгалт авч элсүүлэх (정시)	Их, дээд сургуулийн элсэлтийн шалгалтын дүнгээр жагсаан их сургуульд элсүүлэх журам
Байнгын элсэлт (수시)	Ахлах сургуулийн голч дүн, сургуульд суралцсан байдал зэргийг харгалзан үнэлж их сургуульд элсүүлэх журам
Дугуйлан(С.А) (동아리(С.А))	(С.А. : Club Activity) Сургуулиас тогтоосон хугацаанд ижил хобби, сонирхолтой сурагчид цуглаж хамтран явуулах ажил
Чөлөөт дугуйлан (자유 동아리)	Сургуулиас тогтоосон цагаас гадуур ижил хобби, сонирхолтой хүүхдүүд цуглаж хамтарна.



[Дунд · ахлах сургуульд хэрэглэгддэг үг хэллэг (Үлгэрчилсэн загвар)]

Үг хэллэг	Үндсэн агуулга
Анги дамжин хичээллэх (이동수업)	Ангисаа өөр тусгай зориулалтын анги(зураг, англи хэл, математикийн хичээлийн танхим)–д очиж сонсдог хичээл
Ангийн хурал (학급회의)	Сургуулиас зааж тогтоосон хугацаанд хийдэг ангийн хурал
Сурагчдын зөвлөлийн хурал (학생회)	Нийт сурагчдыг төлөөлөх зөвлөлийн гишүүд цуглаж сурлага, хүмүүжлийн ажлын талаар санал бодлоо хуваалцаж шийдвэр гарган · хэрэгжүүлэх баг
Нийт эцэг эхийн хурал (학부모총회)	Сурагчдын асран хамгаалагчид цуглаж сургуулийн үйл ажиллагааны талаар хэлэлцэх
Хичээлийн дараах сургалт (방과후학교)	Албан ёсны хичээлийн дараа хүсэлтийн дагуу явагддаг хичээл
Бие дааж хичээллэх (자기주도학습)	Сурагч өөрөө биеэ даан хичээллэх
Сайн санааны үйлс (봉사활동)	Сурагч өөрийн болон сургуулийн хамт олны хүсэл, сонирхлын дагуу нийгэм, олон нийтийн ашгийн төлөө хийх сайн санааны ажил
Танилцах дадлага сургалт (현장체험학습)	Сургуулийн сургалт хүмүүжлийн ажлын төлөвлөгөөний дагуу сургалтад шаардлагатай материал бүхий газар очиж танилцуулах сургалт хүмүүжлийн ажил(Жиш: Хавар, намрын дадлага сургалт, танин мэдэхүйн аялал, ажил мэргэжлийн танилцах аялал зэрэг)
Хичээлээс гадуурх дадлага сургалт (교외체험학습)	Сургуулийн захирлын зөвшөөрөлтэйгээр хувиараа танилцах сургалт, соёлтой танилцах аялал, ажил мэргэжлийн танилцах аялал, сургалт хүмүүжлийн ажил(Жиш: Соёлтой танилцах аялал, сургалт, гэр бүлийн аялал, хамаатныдаа зочлох, эмээ өвөөдөө туслах зэрэг)
Сургуулиас тогтоосон амралтын өдөр (재량휴업일)	Сургуулиас амралтын өдрийг тогтоож сурагчдыг нэг өдөр болон тодорхой хугацаагаар амраах хугацаа
Чөлөөт сургалтын тогтолцоо (자유학기제)	Дунд сургуулийн сурагчдаас явц · улирлын эцсийн шалгалт авахын оронд хэлэлцүүлэг · дадлага сургалт болон ажил мэргэжлийн танилцах аялалд хамруулах тогтолцоо
Сургуулийн орчин дахь хүчирхийлэл (학교폭력)	Сургуулийн дотоод болон гадаад орчинд зодуулж бэртэх, хүчирхийлэлд өртөх, хоригдох, сүрдүү лэгт өртөх, мансууруулах бодис хүчээр хэрэглэх · бусдад уруу татагдах, нэр хүндээ гутаалгах, сүрдүүлж худал хэлүүлэх, албадан · хүч хэрэглэн зарах, бэлгийн хүчирхийлэл, гадуурхагдах, мэдээллийн сүлжээнд садар самуун · хүчирхийллийн чанартай мэдээлэлд өртөж бие болон оюун санаа, эд хөрөнгийн хохирол учруулах үйлдлийг хэлнэ.
Долоо хоногийн ажил (Ангийн туслах) (주변(학급도우미))	Анги доторхи багийн гишүүд тогтсон хугацаанд сайн дураараа ангийн ажил хийх

※ Дээрхи үг хэллэг нь тухайн орон нутаг, дунд · ахлах сургуулийн үйл ажиллагааны онцлогоос хамаараад өөр байж болно.



[АПОСТИЛИЙН ГЭРЭЭНД НЭГДСЭН ОРНУУД]

(2019.6.19 байдлаар, 118 улс элссэн)

Эх газрын бүчлэл	Гэрээнд элссэн орнууд
Ази, Номхон далайн орнууд (19)	Шинэ Зеланд, Ниуэ, Маршаллын арлууд, Мавритий, Монгол, Вануату, Бруней, Самоа, Австрали, Энэтхэг, Япон, Хятадын зарим хэсэг(Макао, Хонконг), Күүкийн арлууд, Тажикстан, Тонга, Палау, Фижи, Филиппин, Солонгос
Европ (52)	Араб, Андорра, Австри, Азербайжан, Беларусь, Бельги, Босни-Херцеговина, Болгар, Хорват, Кипр, Чех, Дани, Эстони, Финланд, Франц, Гүрж, Герман, Мальт, Грек, Үнгар, Исланд, Ирланд, Итали, Латви, Литва, Люксембург, Монако, Монтенегро, Нидерланд, Норвег, Польш, Португали, Орос, Румын, Серби, Словак, Словени, Испани, Швед, Швейцари, Турк, Киргизстан, Македон, Украин, Их Британи, Армен, Молдав, Лихтенштейн, Сан-Марино, Казакстан, Үзбекстан, Косово
Хойд Америк (1)	Америк(Гуам,Маури арал, Сайпан, Пуэрто-Рико хамарна)
Өмнөд Америк (30)	Гаина, Гватемал, Гренада, Никарагуа, Доминиканын Бүгд Найрамдах Улс, Доминикан, Мексик, Барбадос, Багам, Венесуэл, Белиз, Боливи, Бразил, Сент Люсия, Сент-Винсент, Сент Кечнебис, Суринам, Аргентин, Антигуа-Барбуда, Эквадор, Эл Салвадор, Гондурас, Уругвай, Чили, Коста Рика, Колумбия, Тринидад Тобаго, Панам, Перу, Парагвай
Африк (12)	Намиби, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс, Либери, Лесото, Малави, Ботсвана, Сао Томе Принсеп, Сейшель, Свазиланд(хуучин Эсватини), Кабо-Верде, Бурунди, Тунис
Ойрхи Дорнод (4)	Бахрейн, Оман, Израиль, Мороко,
Нийт	118 орон

※ [Ашигласан хэвлэл] Апостил бүртгэлийн веб хуудас (www.apostille.go.kr)


※ Апосилийн гэрээнд элссэн орнуудын хамгийн сүүлд гарсан нэрсийн жагсаалтыг Бүгд Найрамдах Солонгос улсын Гадаад Харилц ааны Яамны Гадаад дахь аюулгүй аялал вэб хуудас(www.0404.go.kr)-н Нүүр хуудас → [Консулын үйлчилгээ/Виз] → [Консулын үйлчилгээ] цэснээс шалгах боломжтой

PM2020-85

ОЛОН СОЁЛТ ГЭР БҮЛИЙН ЭЦЭГ ЭХЧҮҮДЭД
ЗОРИУЛСАН ЭЛСЭЛТИЙН ГАРЫН АВЛАГА
ХҮҮХДЭЭ СҮРГҮҮЛЬД ОРҮҮЛАХ НЬ

Хэвлэсэн	2020 оны 12 сар
Редактор	Хүрээлэнгийн захирал Юн Ё Гак
Эрхлэн гаргасан	Насан түршийн боловсролыг дэмжих үндэсний хүрээлэн
Хаяг	Сөүл хот, Жүн-гү дүүрэг, Чон-гэ чон-ру 14, 8-р давхар
Үтасны дугаар	02-3780-9784
факсны дугаар	02-3780-9959
Вэб хуудас	www.edu4mc.or.kr
Дизайн/Хэвлэлт	kncgaram 02-2279-7857

Энэхүү товхимолыг Боловсролын Яам, Насан түршийн боловсролыг дэмжих үндэсний хүрээлэнгээс хэрэгжүүлж байгаа “Олон соёлт гэр бүлийн хүүхдүүдийн сургууль шилжин суралцах тухай танилцуулга –2020” төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн бөгөөд эх материалын зохиогчийн эрхийг Боловсролын Яам, Насан түршийн боловсролыг дэмжих үндэсний хүрээлэн, үг төслийг хариуцан гүйцэтгэх 17 хот, мужийн Боловсролын Газар эзэмшинэ



ОЛОН СОЁЛТ ГЭР БҮЛИЙН ЭЦЭГ
ЭХЧҮҮДЭД ЗОРИУЛСАН ЭЛСЭЛТИЙН
ГАРЫН АВЛАГА
ХҮҮХДЭЭ СҮРГҮҮЛЬД
ОРҮҮЛАХ нь



교육부



국가평생교육진흥원



중앙다문화교육센터

Сөүл хотын Боловсролын Газар
Инчон хотын Боловсролын Газар
Үлсан хотын Боловсролын Газар
Кангвон мужийн Боловсролын Газар
Жонбүк мужийн Боловсролын Газар
Кённам мужийн Боловсролын Газар

Пусан хотын Боловсролын Газар
Гуангжү хотын Боловсролын Газар
Сэжун хотын Боловсролын Газар
Чүнбүк мужийн Боловсролын Газар
Жоннам мужийн Боловсролын Газар
Жэжүгийн Боловсролын Газар

Дэгү хотын Боловсролын Газар
Дэжон хотын Боловсролын Газар
Гёнги мужийн Боловсролын Газар
Чүннам мужийн Боловсролын Газар
Кёнбүк мужийн Боловсролын Газар